



## **Шинжээчийн багийн тайлан**

**БАЙГУУЛЛАГЫН НЭР: АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ  
СУВИЛАХУЙН СУРГУУЛЬ**

**СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН НЭР: ХӨДӨЛГӨӨН ЗАСАЛ**

**Индекс: D091501**

**Шинжээчийн баг:**

**Ахлагч: Т.Алтанцэцэг**

**Гишүүд: Б.Одончимэг**

**М.Үүрийнтуяа**

**2018 оны 11 сарын 27**

**Товчилсон үгийн тайлбар**

**I.Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт.....**

**II.Сургалтын хөтөлбөрийнтанилцуулга.....**

**III.Мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолт .....**

**IV. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт.....**

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт.....

Шалгуур2: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл.....

Шалгуур3: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.....

Шалгуур4: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.....

Шалгуур5: Багшийн үйл ажиллагаа.....

Шалгуур6: Сургалтын үйл ажиллагаа.....

Шалгуур7: Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө.....

Шалгуур8: Чанарын үнэлгээ, баталгаажилт.....

**V.Уулзалтад оролцогчдын нэрс.....**

I. Багш нар.....

II. Оюутнууд.....

III. Ажиллогчид.....

IV. Төгсөгчид.....

**VI.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал.....**

**ҮII.Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр .....**

**ҮIII.Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр.....**

## Товчилсон үгийн тайлбар

АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БСШУЯ	Боловсрол соёл, шинжлэх ухааны яам
ББСТ	Бие бялдар судлалын тэнхим
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
УГТЭ	Улсын гуравдугаар төв эмнэлэг
ГСЗҮТ	Гэмтэл сэргээн засах үндэсний төв
СЗҮТ	Сэргээн засах үндэсний төв
ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
ХНХЯ	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт

## I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр</b>	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Сувилахуйн сургууль School of Nursing, Mongolian National University of Medicine Science	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр</b>	Хөдөлгөөн засал Physical Therapist	
<b>Индекс</b>	D091501	
<b>Шинжээчид</b>	Ахлагчийн нэр, ажил, албан тушаал: 1. Т.Алтанцэцэг: Этүгэн их сургууль, Эрүүл мэндийн сургуулийн захирал Гишүүдийн нэр, ажил, албан тушаал: 2. Б.Одончимэг: Шихихутуг их сургуулийн сургалтын албаны дарга 3. М.Үүрийнтуяа: Эпимон эмнэлгийн ерөнхий эмч	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	Б.Оюунчимэг Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байхажлууд</b>
	2018.11.06	Зохицуулагч шинжээчдийн нэрсийг хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багт илгээж, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар саналыг хүлээн авах
	2018.11.06	Шинжээчийн багийг томилох
	2018.11.06	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2018.11.07	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	2018.11.12	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг зохицуулагчид хүлээлгэн өгнө.
	2018.11.13	Мэргэжилтэн сургууль дээр очиж шинжээч ажиллах бэлтгэлийг хангуулна
	2018.11.14-15	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.

2018.11.26	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
2018.11.27	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
2018.11.30	Магадлан шинжилгээ хийхэд ашигласан өөрийн үнэлгээний тайлан, холбогдох бусад материалыг зохицуулагчид бүрэн хүлээлгэн өгнө.
2018.11.29	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг зохицуулагчид хүлээлгэн өгнө.
2018.11.30	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ
2018.12	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Хөдөлгөөн заслын тусламж үйлчилгээг үзүүлэх мэргэжилтэн нь хөдөлгөөн засалч бөгөөд анх дэлхийн 1-р дайны дараа шархадсан цэргүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биемахбодийн хувьд боломжит түвшин хүртэл сэргээх нийгэмд эргэн оролцуулах зорилготойгоор 1880-аад оноос хөгжиж эхэлжээ.

Манай улсад бакалавр зэрэгтэй “Хөдөлгөөн засалч” мэргэжилтэн нь АШУҮИС болон Япон Улсын Гунма Их сургуулийн хамтын ажиллагааны дүнд 2007 оноос АШУҮИС, Сувилахуйн сургуульд бэлтгэгдэн 8 удаагийн төгсөлт хийж 147 хөдөлгөөн засалч эрүүл мэнд, боловсролын салбарт сэргээн засахын тусламж үйлчилгээг үзүүлж байна. Бие Бялдар Судлалын тэнхим нь 2010-2011 оны хичээлийн жилд үүсгэн байгуулагдсан ба өдгөө үндсэн 9 багш, зөвлөх профессор, цагийн багш нарын хамт 14 багштай хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Хөдөлгөөн засалч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг 2008 оноос хойш тасралтгүй шинэчлэн боловсруулж, 2012 онд ББСТ болон Хөдөлгөөн засалч мэргэжилтний хөтөлбөрийн зөвлөлийн хурлаар мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлүүдийг 4 удаа хэлэлцэн шинэчилсэн байна.

## III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### Үзүүлэлт нотолгоо:

##### 1.1.1 Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал

- Мэргэжилтний эрэлт хэрэгцээ өндөр байгааг бусад улс орны статистик мэдээтэй харьцуулж тооцсон, тухайлбал; хөгжиж буй оронд 100 хүн амд 30-40 хөдөлгөөн засалч ажилладаг байхад өнөөдрийн байдлаар 147 хөдөлгөөн засалч ажиллаж байна. Үүний 90% нь Улаанбаатар хотод ажиллаж байгаа нь цаашид энэхүү чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх, орон нутагт ажиллах мэргэжилтний тоог нэмэгдүүлэх шаардлага гарцаагүй урган гарч байна.

- ЭМС-ын А/67 тоот тушаалаар Хөдөлгөөн засалч мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт батлагдаж, “Эрүүл мэндийн тухай хууль”, “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль-д тус тус Хөдөлгөөн засалч мэргэжилтний ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлжээ.

### **1.1.2 Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар**

- Хөдөлгөөн засалч хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулан “мэргэжилтний цогц чадамж”-ийг өөрийн орны нийгэм соёл, хүрээлэн буй орчны онцлог, зан үйлд нийцсэн, олон улсын стандарт, удирдамжийн хүрээнд боловсруулан хэлэлцүүлэх явцдаа ажил олгогчид, төгсөгчидтэй уулзаж саналыг тусган ажиллаж байна.
- Бакалаврын боловсролтой “Хөдөлгөөн засалч” мэргэжилтнийг бэлтгэхийн тулд CanMEDS-ийн үндсэн 6 үүргийг хослуулсан өндөр мэдлэг, эмнэл зүйн ур чадвартай, мэргэжлийн ёс зүй, хандлага төлөвшсөн мэргэжилдээ дээд зэргээр мэргэшсэн цогц чадамжтай: мэргэжилтэн-менежер, эрүүл мэндийн боловсрол олгогч, судлаач, эргэцүүлэн шинжээч, харилцагч, зөвлөгч байх үндсэн шинжүүдийг Хөдөлгөөн засалч мэргэжилтний загварт тусгажээ.

### **1.1.3 Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/**

- 2018 оны байдлаар Хөдөлгөөн засалч D091501 хөтөлбөрийг манай улсад АШУҮИС, Этүгэн их сургууль хэрэгжүүлж байна.
- АШУҮИС, Этүгэн их сургуулийн хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн суралцах хугацаа, хичээлийн тоо, хичээлийн агуулга ижил байна. Харин Япон улсын Гунма их сургуулийн хөтөлбөрт мэргэшүүлэх хичээлийн тоо, дадлагын цаг илүү тусгагдсан байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөдөлгөөн засалч хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэж эхлэхийн зэрэгцээ мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг батлуулж, “Эрүүл мэндийн тухай хууль”, “Эрүүл мэндийн тусламж тухай хууль-д тус тус Хөдөлгөөн засалч нэршил,эмнэлэгт тавигдах шаардлагыг тусгасан нь туйлын сайшаалтай байна.
- Хөдөлгөөн засалч нь харьцангуй шинэ мэргэжил хэдий ч нийгэмд энэхүү мэргэжлийн ач холбогдолыг таниулж, эрэлт хэрэгцээг бий болгож чадсан.

#### **Анхаарах асуудал:**

- Орон нутагт амьдарч буй иргэдэд үйлчлэх хөдөлгөөн засалч бэлтгэх, төгсөгчдөд хөдөө ажиллах сэдэл төрүүлэх тал дээр анхаарах нь зүйтэй байна.

#### **Зөвлөмж:**

- Орон нутгийн хэрэгцээ, захиалгыг судлах, боловсон хүчнээр хангах

### **1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго**

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

### **1.2.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем**

- Бие бялдар судлалын тэнхим нь Нэгдмэл хөтөлбөрөөр чадамжид суурилсан сургалтыг явуулж байна. Сургалтын SPICES загвараар: **Оюутан төвтэй, асуудалд суурилсан, нийгэмд тулгуурласан, мэдлэгийг дэс дараатай эзэмшүүлэх зарчим баримтлан багаар**

**ажиллах чадвартай** мэргэжилтэн бэлтгэхдээ Мэдлэгийг чадварт шилжүүлэн практикт хэрэглэх зарчим баримтлан Асуудалд, Чадамжид, Харилцаанд ба Даалгаварт суурилсан, Баг/бүлгээр ажиллах ба PPP чадвар эзэмшүүлэх **Сургалтын аргыг** ашиглаж байна.

- **Үнэлгээний систем нь:** Багш, оюутны мэдлэгийн түвшинг үнэлэх, суралцах идэвхийг дэмжих, эрчимжүүлэх, өөрөө өөртөө дүгнэлт хийж, төлөвлөх чадварыг нь багтаан үнэлэх явцын (форматив), төгсгөлийн (сумматив) үнэлгээний систем хэрэгжүүлж байна.
- Явцын үнэлгээ нь оюутны сурах үйл ажиллагаанд туслах, дэмжих, урамшуулах зорилгоор сургалтын үйл ажиллагаанд нөлөөлдөг бол төгсгөлийн үнэлгээ нь сургалтын бүтэн мөчлөг явж дууссаны дараа оюутны мэдлэг, ур чадварын түвшинг тодорхойлж үнэлгээний үнэн бодитой ба хүчин төгөлдөр байдлыг үнэлэх тогтолцоо ажээ.

### **1.2.2 Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал**

- Олон улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн, эрдэм шинжилгээ боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг, үндэсний тэргүүлэх, Ази номхон далайн баруун эргийн бүсийн анагаах ухааны шилдэг 100 их сургуулийн нэг байхад оршино. гэсэн АШУҮИС-ийн эрхэм зорилготой уялдуулан **Сувилахуйн сургуулийн эрхэм зорилгыг Хэрэглэгчийн шаардлагад нийцсэн, инновацийг хэрэгжүүлэгч сувилахуйн жишиг сургууль болно хэмээн тодорхойлсон байна.**
- Хөдөлгөөн засалч хөтөлбөрийн алсын харааг “Монгол улсын эрүүл мэндийн салбарт бие бялдар, хөдөлгөөн засал судлалыг төгс байдлаар нэвтрүүлэн хөгжүүлж, ард иргэдэд хөдөлгөөн засал эмчилгээний үр нөлөө, ач холбогдлыг таниулахад оршино хэмээн томъёолсон байна.
- Хөдөлгөөн засал, хөдөлгөөн судлал, биеийн анатоми, физиологийн үйл ажиллагааг шинжлэх ухаанчаар хэмжиж тогтоосон эрүүл, эмгэг үзүүлэлтийг үнэлэх, анализ хийх, хөдөлгөөн заслын эмчилгээ хийх аргачлалыг сайтар эзэмшүүлэх, хүний эрүүл мэнд нь хүрээлэн буй орчинтой уялдаа холбоотой болох, үйлчлүүлэгчийн зан үйлийг ойлгох, багшийн хяналт дор эмнэл зүйн дадлага хийх мэдлэг, чадварыг хөтөлбөрт тусгасан байна.

### **1.2.3 Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал**

- Монголын Бие Бялдар Хөдөлгөөн Заслын Холбооны жил бүр зохиогддог эрдэм шинжилгээний хуралд оролцсон сэргээн засах тасгийн эмч, мэргэжилтнүүд, ажил олгогчдоос Хөдөлгөөн засал хөтөлбөрийг боловсронгуй болгох тал дээр санал авч тусгасан байна.
- Хөтөлбөрийн шинэчлэл хийх зорилгоор хөдөлгөөн засалчийн төгсөгчдийн төлөөлөл, оюутнууд, багш нар, ажил олгогчидтой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсны дүнд анхны төгсөгчдийг ажлын байраар хангах, мэргэжлийг олон нийтэд таниулсан үр дүнд хүрчээ.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой, төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.
- 2018 оны төгсөлтөөс эхлэн төгсөгчид лицензийн шалгалт өгч эхэлсэн амжилттай байна.
- Төгсөгчид, ажил олгогчидтой нягт хамтын ажиллагаатай ажиллаж байгаа бөгөөд Хөдөлгөөн засалч мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг ижил төстэй сургалтын хөтөлбөртэй харьцуулах, ажил олгогч, эмч, мэргэжилтнүүд, төгсөгчдийн саналыг тусгах замаар 4 удаа шинэчлэн боловсруулсан байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг боловсронгуй болгох асуудалд анхаарах

### **Зөвлөмж:**

- Хөдөлгөөн засалч бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд тусгасан хичээлийн нэршлийг хичээлийн агуулгатай уялдуулан оновчтой болгох
- Эмнэл зүйн тодорхой хичээлийн агуулгад холбогдох лабораторийн шинжилгээний хариу тухайлбал: Рентген зураг, Зүрхний цахилгаан бичлэг унших мэдлэг, чадвар, хандлагыг тусгаж өгөх

### **1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

##### **1.3.1 Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал**

- Хөдөлгөөн засал хөтөлбөрийн индексийг D091501 хэмээн БСШУС-ын 2014 оны А/78 тоот тушаалаар баталгаажуулсан.
- БШУС-ын А/174 тоот тушаалд заасан дээд боловсролын бакалаврын мэргэжлийн хөтөлбөрт тавигдах шаардлагад нийцсэн 4 жилийн 123 багц цагийн сургалтаар сургалтын үйл ажиллагааг явуулж байна.
- Хөдөлгөөн засалч мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг 2007 онд ЭМШУИС-ийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулснаас хойш 4 удаа ББСТэнхимийн хурлаар хэлэлцэн боловсронгуй болгон мөрдөж байна.

##### **1.3.2 Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал**

- Сургалтын хөтөлбөртөө шинийг эрэлхийлэх, санаачлах, асуудал шийдвэрлэх, таамаглал дэвшүүлэх, баримт бичиг боловсруулах, бие даан суралцах гэх мэт хувь хүний, ярих, бичих, баг бүрдүүлэх, удирдах зэрэг харилцааны чадваруудыг тусгасан байна.
- УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ГССҮТ, СЗСҮТ, ЯЦ 10-р төв, Натул эмнэлгүүд дээр эмнэл зүйн ур чадвар эзэмших Танилцах дадлага, Хөдөлгөөн заслын үнэлгээ, Хөдөлгөөн заслын эмчилгээ дадлагуудыг зохион байгуулж байна.

##### **1.3.3 Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал**

- Онол, дадлагын хичээлийг зохистой хослуулж, сургалтанд SCORPIO арга, жижиг бүлгийн хичээл, бататгах сургалт, бие даалтын хичээлээр суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлж байна.
- Оюутан төвтэй сургалтыг танхим, эмнэлгийн дууриамал орчинд зохион байгуулж, оюутнууд бие биенээ үзэх/үнэлэх, багаар ажиллах хэлбэрийг ашиглаж байна.
- Сургалтанд онолын мэдлэг шалгах сорилын шалгалт, шалгах хуудасны дагуу хариулах аман шалгалт, гардан үйлдлийн шалгалт, OSPE үнэлгээний аргуудыг ашиглаж байна.
- OSPE-Гардан үйлдлийг шалгаж үнэлэх тогтолцоотой байгаа нь мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшүүлж, сургалтыг үр өгөөжтэй болгоход чиглэгдэж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Гуршлага:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч боловсон хүчин-багш нар нь залуу боловч тэдний чадавхи сайн байна.

- Төгсөгчид 100% ажлын байраар хангагдсан ба төгсөгчидтэй эргэх холбоо сайтай ажиллаж байгаа нь онол - практикийг зохистой хослуулах, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэх асуудал дээр хөтөлбөрийн шинэчлэлийг оновчтой хийхэд түлхэц болдог сайн туршлага ажиглагдлаа.
- Өөрийн үнэлгээний SWOT шинжилгээнд ахиц дэвшил гаргаж чадсанаа харуулсан БМИҮЗ-ийн тавьж байгаа шаардлагыг биелүүлсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

- Сэдвийн онцлогт тохирсон сургалтын аргыг оновчтой сонгоход анхаарах

#### **Зөвлөмж:**

- Эмнэл зүйн гардан үйлдлийн шалгалтын санг хөдөлгөөн засалчийн ажлын байранд шаардагдаж болзошгүй лабораторийн шинжилгээний хариу /XRау, ЭКГ, MRI/ унших тохиолдлоор баяжуулах
- Дадлагын хичээлийн цаг, чанарын байдалд дүн шинжилгээ хийх, сайжруулах

#### **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 2. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт хийх

#### **2.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

##### **2.1.1.Эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байдал**

- Сургалтын зориулалттай барилга байгууламж нь “Олон нийт иргэний барилга БНБД31-03-03”-д заасан байр, талбайн хэмжээ, эрүүл ахуйн норматив, хөдөлмөрийн эрүүл ахуй, ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015 стандартын шаардлагыг хангасан байна.
- Оюутан болон багш нарыг хөдөлгөөний дутлаас сэргийлж, эрүүл чийрэг ажиллаж сурч хөдөлмөрлөхөд нэмэр болох зорилгоор биеийн тамирын заалыг бүрэн стандартын шаардлага хангахуйц болгон тохижуулж, хуваарийн дагуу үйл ажиллагаа явуулдаг.
- Оюутнуудыг хувийн шүүгээгээр хангаж, хичээлийн байрыг камержуулан, харуул хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллаж байна.

##### **2.1.2.Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, урлангийн хангалт, ашиглалтын байдал**

- Сувилахуйн сургуулийн мэргэжлийн 5 тэнхимийн сургалтын лаборатори, ур чадварын 1 төв, ИСНЭмнэлгийн харьяа Үүдэн эмнэлэг болон сургалтын бааз эмнэлгүүд болох ГССҮТ, УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ,УХТЭ, Сувилал яслалын 10-р цэцэрлэг, Хүүхдийн төв сувилалын сэргээн засах тасгуудын хөдөлгөөн заслын өрөө тасалгаа, анги танхимд түшиглэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- Сувилахуйн сургуулийн Бие Бялдар Судлалын Тэнхим нь Монголын Bayanzurkh Rotary Club, Японы Maebashi Rotary Club-тай хамтын ажиллагааны төслийн хүрээнд хөдөлгөөн засалч мэргэжилтэнг бэлтгэхэд зориулж сургуулийн дэмжлэгтэйгээр 2013 онд хөдөлгөөн заслын лабораторийг тохижуулан уг лабораторид хөдөлгөөн заслын мэргэжлийн хичээлийн дадлага, семинар явуулж байна.



- Бие бялдар судлалын тэнхимийн харьяа “Үүдэн эмнэлэг”-ийг түшиглэн хөдөлгөөн засалч мэргэжлийн оюутнуудын эмнэлзүйн сэтгэлгээ хөгжүүлэх, төгсөлтийн судалгааны ажлыг явуулж байна.
- UNIMIS систем нь Сургалтын Бодлого Зохицуулалтын Газар, багш, суралцагчид, суралцагчдын эцэг эх хоорондын харилцаанд мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглаж ажлын бүтээмжийг дээшлүүлэх, сургалтын мэдээллийн нэгдсэн санг бий болгох үндсэн зорилгын хүрээнд ашиглаж байна.

### **2.1.3. Бие даан болон багаар ажиллах орчны хангалт**

- Сургуулийн 2 давхарт шинээр сандал тавьж тохижуулсан.
- 207 тоот өрөөг багаар ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн.
- 2015 онд Үүдэн эмнэлэгийг байгуулсан бөгөөд оюутнууд бие даан клиник хичээлийн дадлага хийх, багаараа эмнэлзүйн тохилдол дээр ажиллах нөхцөл боломж бүрдсэн.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага**

- PBL-ийн тэнхимтэй болсоноор оюутнуудыг асуудалд суурилсан сургалтыг явуулах орчин бүрдсэн.
- Хөдөлгөөн заслын лабораторийг тохижуулан хөдөлгөөн заслын мэргэжлийн хичээлийн дадлага, семинар явуулж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Сургуулийн хоолны газрын үйлчилгээг сайжруулах
- Оюутнуудын цахим орчинд ажиллаж сурах орчны /ширээ, сандал/ хүртээмжийг сайжруулах

#### **Зөвлөмж:**

- Бие бялдар судлалын тэнхим болон дадлага хийж буй эмнэлгийн сэргээн засах тасгийн уялдаа холбоог сайжруулах

## **2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгсэл**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

### **Үзүүлэлт нотолгоо:**

#### **2.2.1. Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж**

- Мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглаж болох UNIMIS систем нь ажлын бүтээмжийг дээшлүүлэх, сургалтын мэдээллийн нэгдсэн санг бий болгох давуу талтай байна.
- Номын санд нэвтрүүлж, ашиглаж байгаа Koha программ нь нийт 15662 ном, Lib 4U программ нь 21320 ном, CD-ISIS программ нь 9630 ном тус тус оруулсан байна.
- Дижитал хэлний лабораторийн шинэчлэлийн хүрээнд 2011 оноос хойш Digital Language Laboratory /DLL/, Independent Learning Center /ILC/ лаборатори нь сургалтад 19 ширхэг бүхий сүлжээнд бүрэн холбогдсон, иж бүрэн компьютер, нэг нь багшийн PC, үлдсэн 18 нь оюутнуудад англи хэлний сургалтад ашиглаж байна.
- Мөн оноос Net Support School англи хэлний программыг оюутнуудын англи хэлний хэрэглээнд ашигладаг болсон.

#### **2.2.2. Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, багаж тоног төхөөрөмж**

- Хөдөлгөөн засал хөтөлбөрийн багаж тоног төхөөрөмжийн нөөцийг 2008 оноос хойш жил бүр нэр төрөл, тоо хэмжээний хувьд нэмэгдүүлсэн байна. Үүнд: Гониометр (Шугаман) 20, төмөр том гониометр 2, гониометр сет 10, мэдрэлийн алх 6, туузан метр 20, таяг 15, handheld dynamometer электрон сет 1, hand held dynamometer гар 1, шат 1, тэнцвэр сайжруулах бөмбөг 4, мэргэжлийн зориулалтын ор, алхаан зам, эмчилгээний ор 10, зүрхний монитор 1, дээд, доод мөчний булчингийн хүч үнэлэх электрон багаж 1, red cord татлагын багаж 1, TENS

(цахилгаан цочруул) 1, гүйлтийн зам 1, дулаан жин 2, улаан гэрэл 1 тус тус байна.

### **2.2.3. Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж**

- Сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулахын тулд мэдээллийн технологийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Nursing school ISO-9001-2015 Д240 баримт бичгийг баталгаажуулан ажиллаж байна. Мөн сургалтын үед ашигладаг компьютер, проектор, смарт самбар зэргийн аюулгүй ажиллагаа, ашиглалтын зааврыг хичээлийн өрөөнүүдэд байршуулсан. 10 орчим төрлийн цахим хичээлийг дүрсжүүлэн гаргаж, 10 орчим мэргэжлийн чиглэлийн гарын авлага ашиглаж байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Номын сангийн программуудыг ашиглан олон нэр төрлийн номыг онлайн байдлаар нэвтрүүлсэн.
- Unimiss системийг ашиглан оюутан, эцэг эх, арга зүйч нарын харилцан холбоог сайжруулсан.

#### **Анхаарах асуудал:**

- Хичээл практикт ашиглаж буй багаж тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх

#### **Зөвлөмж:**

- Эрүүл мэндийн яамны салбар зөвлөл, тэнхим холбоо хамтран хөдөлгөөн засал эмчилгээний удирдамжийг гаргах

### **2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

#### **2.3.1 Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний бүтээлийн судалгаа, хүртээмж хэрэглээ**

- АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн номын сан нь үндсэн болон ойрын фондтой ба уншлагын 2 танхим 82 суудалтай, цахим уншлагын 1 танхим 25 компьютертэйгээр оюутнуудад үйлчилдэг байна.
- Номын сан нь нийт 21792 ш номтой, үүнээс хөдөлгөөн засалч мэргэжлийн 60 нэр төрлийн 157 ширхэг ном байна. Монгол хэлээр 18223, орос хэлээр 1687, англи хэлээр 1825 ширхэг ном, япон хэлээр 57 ширхэг номтой. Цахим хэлбэрээр англи 120, монгол 20 номыг оюутнуудад хүргэж үйлчилж байна.

### 2.3.2 Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал

- Монгол хэл дээрх ховор сурах бичгийг скайнердаж цахим хэлбэрт хөрвүүлсэн /Цахим хэлбэрт хөрвүүлэх номыг сонгохдоо уншигчдын хэрэгцээ шаардлагыг үндэслэн, их сургуулийн сурах бичгийн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг ба хувилах, хуулбарлах боломжгүйгээр уншигчдад хүртээдэг/
- Нээлттэй эх үүсвэрүүд дээр тулгуурлан уншигчдын эрэлтийг үндэслэн гадаад номыг цахимаар бүрдүүлсэн.
- Олон улсын онлайн мэдээллийн сангуудын тоог нэмэгдүүлэх, сургалт сурталчилгаанд хамрагдаж оюутан багш нарт туслалцаа үзүүлдэг.
- HINARI хандалтыг 2005 оноос 2014 он хүртэл АШУҮИС-ийн номын санд үнэ төлбөргүй ашиглаж ирсэн. 2014 оноос эхлэн Монгол улсын эдийн засгийн хөгжлөөс шалтгаалж бага төлбөртэй ашиглах болсон. 2014 онд 1000 ам.доллар, 2015 онд 1500 ам.доллар төлсөн байна. БСШУЯ-ны төслөөр Springer, Ensco Host мэдээллийн сангуудыг 1 жилийн хугацаатай туршилтаар ашиглаж байна.

### 2.3.3 Цахим орчны хүртээмж хэрэглээ

Цахим номын сангийн фондыг дараах арга замаар бүрдүүлэн баяжуулсан.

- Олон улсын нээлттэй мэдээллийн сангийн хандалтыг нэмэгдүүлэн, төлбөртэй мэдээллийн сангийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, шаардлагатай мэдээллийн санг худалдан авсан.
- Хөдөлгөөн засалч нарын онлайн номын санг хөтлөн ажиллуулж байгаа ба тухайн номын санд хөдөлгөөн заслын чиглэлийн 150 гаруй ном сурах бичиг шууд татаж авах хэлбэрээр байршуулсан байна.

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Цахим номын санг бүрдүүлсэн

#### Анхаарах асуудал:

- Ном сурах бичгийг эх хэл дээр бэлтгэх /онол болон дадлага/
- Оюутнуудын номын сангийн үйлчилгээний талаарх сэтгэл ханамж 40 гаруй хувь байна.

#### Зөвлөмж:

- Сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авах, судалгааны үр дүнгийн дагуу ажлын төлөвлөгөө гарган ажиллах

### 2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

## Шалгуур 3. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

### 3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### Үзүүлэлт нотолгоо:

##### 3.1.1. Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал

- АШУҮИС-ийн багш нар өөрийн заадаг хичээлийн тэмдэглэл, сорилыг цахим хэлбэрээр бэлтгэн цахим сургалтын аргыг нэвтрүүлжээ. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын хүрээнд багш нараас авсан санал асуулгын дүнд сургалтын удирдлага мэдээллийн ашиглалт, хяналт, ил тод байдлыг “Хангалттай” 98% хэмээн үнэлсэн байна.

### **3.1.2. Хөтөлбөрийн нэгжийн /тэнхим, профессорын баг, хөтөлбөрийн хороо/ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангасан байдал**

- ББСТ нь нийт 9 багшийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж хичээлийн сэдэв, агуулгын давхардлыг арилгах, уялдааг сайжруулах асуудлуудыг дэд зөвлөлөөр хэлэлцүүлэн гарсан шийдвэрийн дагуу АШУҮИС-ийн хөтөлбөрийн хороонд санал оруулж Хөдөлгөөн засалч бакалаврын мэргэжлийн 24 нэр томъёог баталгаажуулсан нь мэргэжлийн дипломд бичигдэж байна.

### **3.1.3. Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт**

- Сургалтын үйл ажиллагаа эрхлэх явцаа: БСШУС-ын А/174 тушаалын хавсралт “Дээд боловсролын бакалаврын мэргэжлийн хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”, “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”, “Суралцагчийг үнэлэх журам”, “Сургалтын технологи, хяналтын үлгэрчилсэн журам”, АШУҮИС-ийн хэмжээнд мөрдөх, биелүүлэх “Багшийн алтан дүрэм”, “Багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам” зэрэг холбогдох дүрэм, журмуудыг мөрдөж хэрэгжүүлж байна.

### **3.1.4. Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм**

- ББСТ-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөөний биелэлтийг 2017 онд дүгнэж үзэхэд 94,7%-тай байна. Хөдөлгөөн засалч мэргэжлээр элсэгчдийн ЭЕШ-ийн босго оноог 700 хүргэх зорилт хэрэгжээгүй, мэргэжлийн сурах бичиг, ном гаргах явц удаашралтай байна.

### **3.1.5. Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, систем бүрдсэн байна.**

- Сүүлийн 5 жилд хөдөлгөөн засалч мэргэжлээр суралцагчдаас нийт 3 санал хүсэлт оюутны албанд ирж, санал хүсэлтийг 100% шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.

### **3.1.6. Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилт**

- 2018-2019 оны хичээлийн жилд ББСТ нь 9 багшийн бүрэлдэхүүнтэй ажиллаж, Гунма их сургуулийн дэд профессор Наказава Риез, Касүяама Тацү нар лекц, семинарыг зохион байгуулж байна. АШУҮИС-ийн хэмжээнд мөрдөх, биелүүлэх “Багшийн алтан дүрэм”, “Багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам”-ын дагуу 2016 онд Д.Батлхам “АШУҮИС-ийн шилдэг багш”-аар шалгарсан. ББСТэнхимийн 2 багш докторын сургалтын төлбөрөөс 30% хөнгөлөлт авсан байна.

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Удирдлага мэдээллийн UNIMIS нэвтрүүлснээр нэгж, албадын ажлын үзүүлэлт, явц, үнэлгээ ил тод болжээ.
- Суралцагчид, төгсөгчид өөрийн сургалт, хөтөлбөрийн хэрэгжилтэд сэтгэл хангалуун байна.
- Багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын хүрээнд Японы Гунма их сургуультай багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж байна.

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар төгсөгчид, суралцагчдаас авах санал асуулгыг тогтмолжуулах

### **Зөвлөмж:**

- Богино хугацаанд хөдөлгөөн засалч мэргэжлийг нийгэмд таниулж чадсан амжилтаа хадгалах, бататгах

## **3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

##### **3.2.1. Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж**

- ББСТ нь жил бүр ажил олгогчид болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдийн удирдлага, алба нэгжийн дарга нартай уулзалт зохион байгуулж, мэргэжлийн онцлог, мөн чанарыг таниулж тэдний санал зөвлөгөөг авч ажиллаж байна.

##### **3.2.2. Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө**

- Мэргэжил сурталчлах нээлттэй өдөрлөг зохион байгуулж, тэнхимийн үйл ажиллагааг цахим хуудсаараа дамжуулан нийтэд таниулж байна. Хөтөлбөрийг болон мэргэжлийг таниулах зорилгоор МИДСК-аас зохион байгуулдаг “Боловсролын үзэсгэлэн”-д оролцох, мэргэжлийн онцлогийг таниулсан брошур бэлтгэх, ерөнхий боловсролын сургуулиудаар сурталчилгаа, таниулга хийх, ТҮ болон бусад мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлууд зохиогджээ.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төлөөлөл болох 14 ажил олгогчидтой уулзалт зохион байгуулахад Хөдөлгөөн засалч мэргэжилтэнд сэтгэл хангалуун байлаа.

#### **Анхаарах асуудал:**

- Мэргэжил суртачилах маркетингийг өргөжүүлэх

#### **Зөвлөмж:**

- Хөдөлгөөн засалч хөтөлбөрийн зах зээлийн тандалтыг олон улсын сайн туршлагад тулгуурлан хийж, улсын хэмжээнд шаардагдах хүний нөөцийн/мэргэжилтний тооцоог хийх

### **3.3 Төгсөлтийн дараах бодлого**

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

##### **3.3.1. Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа**

- Хөдөлгөөн засалч мэргэжлээр төгсөгчдийн 2 нь тэнхимдээ багш, 119 хөдөлгөөн засалч төрөлжсөн нарийн мэргэжлийн улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүд, боловсролын байгууллагуудад ажиллаж байна. Төрсөн шалтгааны улмаас 6 хөдөлгөөн засалч ажил эрхлээгүй байна. Х.Энхчимэг, Б.Янжинсүрэн, П.Мөнхжаргал нар Гунма их сургуульд магистрын зэргээ амжилттай хамгаалсан байна.

##### **3.3.2. Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ**

- Төгсөгчдийн 20% орчим нь магистрант, доктронтурын сургалтад үргэлжлүүлэн суралцжээ. 2011 оноос хойш нийт төгсөгчдийн 3,1% магистрийн зэрэг хамгаалсан байна. Тэдний 50% нь Япон улсад хамгаалсан байна. 2018 оны байдлаар 4 төгсөгч Япон, Солонгос улсад үргэлжлүүлэн суралцаж байна. Б.Мөнх-Эрдэнэ, Г.Намуун, Б.Янжинсүрэн нар Япон, Австрали улсуудад доктронтурын сургалтад суралцаж байна.

##### **3.3.3. Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал**

- Япон улсын Гунма их сургуульд 2017 оны байдлаар 10 төгсөгчийг төгсөлтийн дараах сургалтад хамруулсан дүнтэй байна. Төгсөлтийн дараах сургалтыг дараах 4: Мэдрэлийн хөдөлгөөн засал, Тулгуур эрхтэн тогтолцооны хөдөлгөөн засал, Хүүхдийн хөдөлгөөн засал, Дотор өвчний хөдөлгөөн засал чиглэлээр явуулахаар хөтөлбөрийг боловсруулж байна.

##### **3.3.4. Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал**

- АШУҮИС-ийн Төгсөгчдийн холбооны журмын дагуу ажиллахын зэрэгцээ Монголын бие бялдар хөдөлгөөн заслын холбоонд нэгдэн ажиллаж иргэдэд эрүүл мэндийг дэмжих, хөдөлгөөний чадвар алдагдуулах өвчин эмгэгээс сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчид Австрали, Япон, Солонгос улсуудад үргэлжлүүлэн суралцаж байна.

### Анхаарах асуудал:

- Өндөр хөгжилтэй улс оронд суралцаад эх орондоо эргэн ирж мэдлэг, чадвар, хандалгаа бусад хөдөлгөөн засалч нарт түгээх асуудалд анхаарах
- Төгсөлтийн дараах сургалтаар төгсөгчдөд төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшүүлэх

### Зөвлөмж:

- Өөрийн оронд төгсөлтийн дараах сургалтад хамрагдах боломжийг дэмжих, тогтолцоог боловсронгуй болгох
- Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх
- Магистрантур, докторантурт элсэгчдийн элсэлтийн хүрээг өргөтгөх бодлого баримтлах

## 3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

### Үзүүлэлт нотолгоо:

#### 3.4.1. Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт

- Япон улсын Гунма их сургууль, Швейцарийн Цүрихийн их сургуультай хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.

#### 3.4.2. Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо

- Сүүлийн 10 жилийн хугацаанд 3 багш гадаад, 2 багш дотоодын докторын сургалтад хамрагдсан ба Гунма их сургуульд төгсөлтийн өмнөх сургалтаар 93 оюутан солилцооны хөтөлбөрөөр, 19 төгсөгч төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан байна.

#### 3.4.3. Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол

- Хөдөлгөөн заслын чиглэлээр 3 удаа олон улсын хурал семинарт давхардсан тоогоор 9 багш оролцжээ. Сүүлийн 5 жилд нийт 27 төсөлт ажилд багш нар оролцсон байна. 2012-2017 оны хугацаанд олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлд 11 бүтээл хэвлүүлсэн байна. Шинэ салбар хэдий ч 2015 онд Дэлхийн хөдөлгөөн заслын холбоонд гишүүнээр элсэж олон улсын хэмжээнд өөрийн мэргэжил, салбарын нэрийг гаргаж чадсан амжилттай байна.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Япон улсын Гунма их сургууль, Швейцарийн Цүрихийн их сургуультай нягт хамтын ажиллагаатай ажиллаж тэргүүн туршлагыг сургалт, үйлдвэрлэлд нэвтрүүлж байна.
- Дэлхийн хөдөлгөөн заслын холбоонд гишүүнээр элссэн амжилттай байна.

### Анхаарах асуудал:

- Цаашид багш нар, төгсөгчид өндөр хөгжилтэй оронд суралцаж, нарийн мэргэших санхүүгийн боломжийг бий болгох тал дээр анхаарах

### Зөвлөмж:

- Гадаадын сургуулиудтай хийж буй багш, оюутан солилцооны хөтөлбөрийг улам бүр өргөжүүлэх тал дээр төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх
- Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх

### **3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

#### **3.5.1. Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн**

- Сургалтын үйл ажиллагааг АШУҮИС-ийн Анагаах, Биоанагаах, Эм зүй, Нийгмийн эрүүл мэнд, Сувилахуй зэрэг 5 сургуулийн тэнхим нэгжүүдтэй болон Гадаад хэлний төвтэй хамтран хэрэгжүүлж байна. Түүнчлэн хамтран ажилаж буй сургууль, эмнэлгүүдтэй харилцан туршлагаа солилцон АШУҮИС-ийн эмнэлгийн харьяа Үүдэн эмнэлгийг байгуулж үйл ажиллагааг нь тогтмолжуулсан. Монголын бие бялдар хөдөлгөөн заслын холбоо, Бие бялдар сэргээн засах судлалын үндэсний нийгэмлэг, УНТЭ,УХТЭ,УГТЭ, Тархины саа саажилттай хүүхдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг зэрэг байгууллагуудтай хамтран хөдөлгөөн засалч нарын нийгэм, эрх зүйн орчинг сайжруулах, төгсөлтийн дараах тасралтгүй сургалтыг зохион байгуулах, судалгаа шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

#### **3.5.2. Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт**

- Гунма их сургуультай байгуулсан “Gunma exchange program” сургалтад 7 багш, 49 оюутан танилцах дадлага хийжээ. Maebashi Rotary Club-тай хамтран тоног төхөөрөмж сайжруулах төслийг амжилттай хэрэгжүүлсэн.

#### **3.5.3. Хамтын ажиллагааны арга, туршлага**

- Монголын бие бялдар хөдөлгөөн заслын холбоотой хамтран хөдөлгөөн засал эмчилгээг хөгжүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн дэмжих зорилгоор 2011 оноос хойш 8 удаа эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулжээ. Түүнчлэн төгсөлтийн дараах тасралтгүй сургалтад давхардсан тоогоор 850 хөдөлгөөн засалчийг хамруулсан байна. Багш шавийн Зудаагийн уулзалтыг Архангай, Хөвсгөл, Улаанбаатар хотод зохин байгуулжээ.

#### **3.5.4. Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/**

- 2015 онд байгуулсан Үүдэн эмнэлэгт оюутнууд эмнэл зүйн дадлага хийх боломжтойгоос гадна тус тэнхимийн багш нар хүмүүнлэгийн шугамаар иргэдэд үнэ төлбөргүй үзлэг, оношлогоо хийж, эмчилгээ хийж, зөвлөгөө өгч ажилладаг байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Монголын бие бялдар хөдөлгөөн заслын холбооны хүрээнд гадаад болон дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж ажиллаж байна.

**Анхаарах асуудал:**

- Дотоод хамтын ажиллагаа тухайлбал; төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт Улаанбаатар хотод түлхүү байна.

**Зөвлөмж:**

- Төгсөгчидийн ажил эрхлэлт, карьерын өсөлт, сургалтанд хамрагдалт зэргийг анхааран Төгсөгчидийн холбоог байгуулах түүгээр дамжуулан олон талт өгөөжтэй арга хэмжээнүүд зохион байгуулах

### **3.6 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

#### **3.6.1. Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил**

- АШУҮИС-ийн хэмжээнд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай Монгол улсын хуулийн дагуу төвлөрүүлэн захирч, зарцуулах журмаар үйл ажиллагаа явагдаж байгаа нь Монгол улсын санхүүгийн талаар баримтлаж байгаа хууль эрхийн орчинд нийцнэ.

АШУҮИС-ийн хэмжээнд мөрдөгдөж байгаа Хөгжлийн бодлогын баримт бичигт төсөв санхүүгийн эх үүсвэрийг олон талтай болгох, биеэ даасан байдлыг сайжруулах талаар заалт оруулсан байна. АШУҮИС-ийн захиргаа бүрэлдэхүүний ба харьяа сургуулийн жилийн төсвийг нэгжээс авч, аль болох нэгж байгууллагын саналыг үндэслэн төсөв зохиох санхүүжилт, хуваарилалтыг хийх талаар санаачилга гарган ажилласан байна.

### 3.6.2. Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо

- Нэг оюутанд ногдох зардал жилээс жилд өсч байгааг дараах хүснэгтээс харж болно.

Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо

№	2013	2014	2015	2016	2017	2018
Сургалтын төлбөр	1,121.839	1,098.820	1,415.305	1,869.436	1,976.940	

### 3.6.3. Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв

- Төсөвийг сургалтын материал, ур чадварын тоног төхөөрөмж худалдан авах, оюутны хөгжилд зориулсан үйл ажиллагаанд зарцуулсанг тайлан, илрэл нотолгооноос харж байна.

### 3.6.4. Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт

- Тайланд тодорхой мэдээлэл байсангүй.

### 3.6.5. Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт

- Хичээл нөхөлтийн төлбөр, Өвөл, зуны дахин сургалтын төлбөр, Дахин шалгалтын төлбөрөөс бүрддэг байна. Их сургуулийн захирлын А/102 тоот тушаалын дагуу эдгээрээс орсон орлогын 50 хувийг сургуулийн төсвийн гаднах орлогод тооцон үлдсэн 30 хувийг багш ажиллагсадын ажлын хөлсөнд, 20 хувийг багш, оюутныг хөгжүүлэхэд зарцуулдаг юм байна.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн санхүүжилтийг бүрдүүлэх, төсөв хувиарлах, зарцуулах үйл ажиллагаа Монгол улсын санхүү бүртгэлийн хуулийн нөхцөлд зөрчилгүй явагдаж байна.

### Анхаарах асуудал:

- Багш, ажилчдын нийгмийн асуудлыг шийдэхэд хувь нэмэр болохуйц санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх асуудлыг анхаарах

### Зөвлөмж:

- Үүдэн эмнэлгийн үйл ажиллагааг өргөжүүлэн төлбөртэй үйлчилгээ үзүүлж иргэдэд илүүтэй хүрэх замаар төсөвт хувь нэмэр оруулах боломжийг судлах

## 3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

## Шалгуур 4. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### 4.1 Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### Үзүүлэлт нотолгоо:

#### 4.1.1. Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал

- Элсэлтийн журмыг жил бүр шинэчлэн элсэгчдийн хими, биологийн мэдлэгийн босго



оноог хөтөлбөрийн онцлогтой уялдуулан тогтоож байсныг тайланд тусгажээ. Жил бүрийн элсэлтийн шалгалтын журмын заалтуудаар нотлогдож байна.

#### **4.1.2. Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа**

- Элсэлтийн квоттой харьцуулахад сүүлийн таван жилийн хугацаанд 2-4 оюутан дутуу элсүүлж байсан бөгөөд 15/16 оны хичээлийн жилд 6 оюутан илүү элсүүлснийг тайланд тусгажээ. ЭШ-ийн оноог сүүлийн 4 жилээр харуулсан бөгөөд биологийн хичээлийн шалгалтын дундаж оноо 522.9, химийн хичээлийн шалгалтын дундаж оноо 516.5 байгаа нь БСШУСЯ-ны тогтоосон 400 онооноос 112-116 оноогоор илүү байгаа нь элсэгчдийн чанар харьцангуй тогтвортой, шаардлага хангасныг илэрхийлж байна.

#### **4.1.3. Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангасан байдал**

- Тайланд энэ талаар оновчгүй мэдээлэл байршуулсан боловч сургалтын албаны ажилтантай ярилцснаар элсэгчдэд зориулсан 0 долоо хоногийн хичээлээр сургалтын дүрэм, журам оюутанд зориулсан үйлчилгээний талаар тодорхой мэдээлэл өгч хэвшсэн байгааг тодруулав. Мөн жил бүр оюутны гарын авлагыг дүрэм, журмын эмхэтгэл хэлбэрээр UNIMIS системийн оюутны вебэд байршуулдаг болохыг цахимаар танилцав.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Тайланд тусгасан тоо баримтад статистик боловсруулалт хийж, оновчтой дүгнэлт гаргах шаардлагатай.

### **4.2 Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

##### **4.2.1. Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үрдүн**

- Оюутны клуб, оюутанд үйлчлэх алба, оюутны зөвлөл, хөдөлмөрийн бирж зэрэг байгууллагууд нь жил бүр ажлын төлөвлөгөө гаргаж албажуулан ажилладаг нь тайлан болон уулзалт ярилцлагаас тодорхой харагдаж байна.

##### **4.2.2. Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт**

- Сүүлийн 5 жилд оюутанд үйлчлэх үйлчилгээг үнэлүүлж, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдэж байгааг тайланд тоо баримтаар харуулсан байна. Мөн бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар анги бүрд зөвлөх багш томилон ажиллуулж байна.

##### **4.2.3. Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал**

- Клубээр дамжуулан оюутны харилцаа, хандлагыг сайжруулах ажлыг тогтмол зохион байгуулдаг нь оюутнуудтай хийсэн ярилцлагаар тодорхой байв.

##### **4.2.4. Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал**

- Оюутны клубээр дамжуулан сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулдаг. Оюутны нийгэмлэгийн зүгээс шилдэг клуб шалгаруулж, шилдэг оюутныг нийгэмлэгийн гишүүнээр элсүүлэх зэрэг албан бус урамшуулалтай. Ярилцлага, эрх зүйн баримт бичгийн судалгаагаар суралцагчдын сайн дурын үйл ажиллагааг багц цагт тооцдоггүй болохыг тодруулав.

##### **4.2.5. Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал**

- ХНХЯ-тай хамтран дүүргийн хэлтсээр дамжуулан хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг. Төгсөгчдийнхөө 50 шахам хувийг ажлын байранд зуучилж өгсөн. Энэ хичээлийн жилд 17 оюутныг цагийн ажилд зуучлан хөдөлмөр эрхлүүлсэн байна.

##### **4.2.6. Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусласан байдал**

- Тус хөтөлбөрийн суралцагчид 4 дүгээр дамжаандаа судалгааны ажил хийж, бүтээлүүдээр нь оюутны ЭШХ-ын эмхэтгэлийг жил бүр хэвлүүлэн гаргадаг байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөдөлмөрийн биржийн ажиллагаа тогтмолжсон, үр дүнтэй хэрэгжиж байна.
- Оюутны судалгааны ажлыг сайн дэмжиж байна.

#### **Зөвлөмж:**

- Оюутны сайн дурын ажил буюу нийгэмд чиглэсэн сайн үйлсийг багц цагаар тооцож, үнэлэх талаар санаачилгатай ажиллах

### **4.3 Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг**

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

#### **4.3.1. Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал**

- Оюутны зөвлөлөөр дамжуулан клубын системээр сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулдаг. Сургуулийн захиргаа, оюутны алба, тэнхимүүд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад чиглүүлэн зөвлөж, албажуулан удирддаг байна.

#### **4.3.2. Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдал**

- РТс клубын үйл ажиллагааг зөвлөх багш нар тогтмол чиглүүлэн удирдаж ирсэн байна. Сувилахуйн сургуулийн оюутны нийгэмлэг нь АШУҮИС-ийн оюутны холбооны дэд нэгж багаад оюутны холбоогоор дамжуулан үйл ажиллагааны зардлаа авдаг гэсэн тайлбарыг Оюутны ажил хариуцсан арга зүйч Л.Төмөрсүх гаргаж өгөв. Тайлбараас харахад 2018 онд АШУҮИС нь Оюутны холбоонд 26.646.900 төгрөг төсөвлөснөөс 2 сая төгрөгийн санхүүжилтыг Сувилахуйн сургуулийн оюутны холбоонд хуваарилсан байна.

#### **4.3.3. Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал**

- Санхүүгийн тайланг тусгайлан гаргаж, хэлэлцүүлэх талаар мэдээлэл өгөөгүй. Сайт болон бусад хэрэгсэлд байршуулаагүй байна. Ерөнхий тайланг бичгээр гаргадаг боловч, нийт оюутнуудад түгээх талаар тодорхойгүй байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Зөвлөмж:**

- Оюутны байгууллагын санхүүжилтыг тухайн жилийн оюутны төлбөрийн тодорхой хувиар, нийт оюутны тоонд нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогтоо тохируулан тооцуулж авч хэвших
- Клуб, нийгэмлэгийн зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнаж, нийтэд түгээн танилцуулах соёлыг төлөвшүүлэх шаардлагатай.

### **4.4 Суралцагчийн урамшууллын тогтолцоо**

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

#### **4.4.1. Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо**

- Урамшуулал, тэтгэлэг, хөнгөлөлтийн талаар нээлттэй эх сурвалжуудыг түгээж, болзол хангасан суралцагчдыг бүрэн хамруулж ирсэн байна. Гэвч тооцоо судалгаа танилцуулаагүй.

#### **4.4.2. Суралцагчдын үзүүлсэн амжилтууд**

- Суралцагчдын үзүүлсэн амжилтуудыг гадаадад дадлага хийхээр шалгарч дадлагажсан суралцагчдын тоогоор илэрхийлсэн бөгөөд сүүлийн 4 жилд 16 оюутан гадаадад дадлагажсан байна.

#### 4.4.3. Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг

- АШУҮИС-ийн захирлын нэрэмжит тэтгэлгийг сүүлийн 2 хичээлийн жилд 5 оюутан хүртсэн мэдээлэл тайланд тусгажээ.

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

##### Анхаарах асуудал:

- Урамшуулал, тэтгэлэг, хөтөлбөрт хамрагдсан суралцагчдын тоог сүүлийн 5 жилээр тооцож гаргах

#### 4.5 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

##### Үзүүлэлт нотолгоо:

#### 4.5.1. Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал

- АШУҮИС-ийн захирлын А/142 тушаалаар баталсан “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.4.1 дэх заалтаар шилжилт хөдөлгөөн, хичээл дүйцүүлэлтийг тооцдог байна.

#### 4.5.2. Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт

- Сүүлийн 5 жилд тухайн хөтөлбөрт 2 оюутан шилжин ирж, 3 оюутан хөтөлбөрөө сольсон байна. Үүний шалтгаан, үр дагаврыг судлан дүгнэсэн дүгнэлт гаргаагүй.

#### 4.5.3. Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал

- Суралцагчтай хийсэн гэрээний хэрэгжилтийн талаар санал гомдол гараагүй. Сургалтын хөтөлбөрөөс гадуур эзэмшсэн гадаад хэлний чадамжийг гадаад хэлний хичээлтэй дүйцүүлэн тооцдог байна. Шилжилт хөдөлгөөн, багц цаг дүйцүүлэлтийн талаарх эрх зүйн актууддаа оюутны эрх ашиг хөндөгдөж байгаа эсэх талаар дүгнэлт гаргаагүй байна.

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

##### Анхаарах асуудал:

- Шилжилт хөдөлгөөний шалтгаан, үр дагаврыг судлан дүгнэлт гаргах, шилжилт хөдөлгөөн, багц цаг дүйцүүлэлтийн талаарх эрх зүйн актуудад оюутны эрх ашиг хөндөгдөж байгаа эсэх талаар дүгнэлт хийх.

#### 4-р шалгууринталаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

## Шалгуур 5. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### 5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилгоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

##### Үзүүлэлт нотолгоо:

### **5.1.1. Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: тушаал, урамшууллын бодлогосонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт**

- Хөтөлбөрийн хүний нөөцийн бодлого нь АШУҮИС-ийн захирлын А/118 дугаар тушаалаар батлагдсан “АШУҮИС-ийн багшийн үйл ажиллагааг зохицуулах журам”, “АШУҮИС-ийн багшийн алтан дүрэм” зэргээр зохицуулагддаг. Энэ журмын сонгон шалгаруулалтын дагуу сүүлийн 5 жилд 7 багш шинээр ажилд орсон байна.
- Тус хөтөлбөр нь мэргэшүүлэх хичээлийн багшлах боловсон хүчинг Японы Гунма Их Сургуулийн Анагаах Ухааны салбар сургуульд системтэй бэлтгэж байгаа нь тайлан болон ярилцлага, баримтуудаар нотлогдож байна. Мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хөдөлгөөн засалчдын олон улсын хуралд багш нараа тогтмол хамруулдаг.

### **5.1.2. Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилгоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.**

- Хөтөлбөрийн мэргэшүүлэх сургалтыг хөтлөх 11 багшийн 50 хувь нь 8-25 жил ажилласан, 50 хувь нь 1-5 жил ажилласан багш нар байгаа нь харилцан туршлага, мэдлэгээ хуваалцах зохистой харьцаа гэж үзэж байна. Тэдний зочин профессороор Японы Гунма Их сургуулийн Ph.D профессорууд, Монгол улсын ШУГТЭ-ийн их эмч нар ажиллаж байна.

### **5.1.3. Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин**

- Хөтөлбөрийн мэргэжлийн суурь хичээлүүдийн багш нарын 37,5 хувь нь доктор зэрэгтэй. Ерөнхий суурь, мэргэшүүлэх хичээлүүдийн багш нар хараахан докторын зэрэггүй боловч мэргэшүүлэх хичээлийн багш нарын 54,5 хувь нь докторантурт суралцаж байна.

### **5.1.4. Багш суралцагчдын тооны зохистой харьцаа**

- Сүүлийн 5 жилд хөтөлбөрийн багш, суралцагчийн харьцаа харьцангуй тогтвортой, 1:14 харьцаатай байгаа нь төгсөгчийн чанарт эерэгээр нөлөөлөх боломжтой.

### **5.1.5. Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал**

- АШУҮИС-ийн захирлын зөвлөлийн 2014 оны 5 дугаар сарын 18-ны өдөр хэлэлцэн баталсан багш “Багшийн алтан дүрэм”-ийн дагуу багшийн албан тушаалын ангилал зэрэглэлийг хэрэгжүүлдэг. 2013/2018 оны байдлаар дадлагажигч багш 3/3, багш 2/5, ахлах багш 2/3 болж зэрэглэл ахисан байна.

### **5.1.6. Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал**

- Багшийн ажлын гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилсан багш нарыг урамшуулах бодлого тогтвортой хэрэгждэг. Тухайлбал, мэргэшүүлэх хичээлийн 2 багш докторантурын сургалтын төлбөрөөс 30 хувийн хөнгөлөлт эдэлсэн. Тэнхимийн эрхлэгчийн ачааллаас 5 хувийн хөнгөлөлт үзүүлсэн.

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл:**

• Мэргэшүүлэх хичээлийн багшлах нөөцийг гадаадад тууштай, оновчтой бэлтгэж, тогтвортой ажиллуулж байна.

### **Анхаарах асуудал:**

- Мэргэшүүлэх хичээлийн багш нарыг практик байгууллагад/эмнэлэг, сувилал, сургууль, цэцэрлэг/ дадлагажуулах талаар анхаарч ажиллах шаардлагатай.

## **5.2 Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

### **Үзүүлэлт нотолгоо:**

#### **5.2.1. Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал**

- АШУҮИС-ийн Багшийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан хэрэгцээ тодорхойлох цахим судалгаанд тогтмол хамрагддаг. 2018 оны судлагаагаар хөтөлбөрийн багш нарын 82 хувь нь судалгааны арга зүй, боловсруулалтаа хөгжүүлэх, 69 хувь нь заах арга зүйгээ хөгжүүлэх, 76 хувь нь англи хэлний мэдлэгээ хөгжүүлэх хэрэгцээтэй байсан байна.

#### **5.2.2. Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт**

- “Багшийн алтан дүрэм” нь АШУҮИС-ийн багш хөгжүүлэх тулгуур баримт бичиг бөгөөд хөтөлбөрийн багш нар хэрэгжилтэд хамрагдан суралцдаг байна. Харин хөтөлбөрийн багшийн хөгжлийн хөтөлбөр хараахан гараагүй байна.

#### **5.2.3. Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал**

- Хөтөлбөрийн нийт багш нар сүүлийн 5 жилд АШУҮИС-ийн “Багш хөгжлийн төв”-ийн 188 сургалтад хамрагдсан байна. Анагаах ухааны боловсрол судлал, сургалтын арга зүй, үнэлгээний арга зүй, англи хэлний хичээлүүдэд түлхүү хамрагджээ. Мэргэжлийн багш нарыг 3 сараас 1 жилийн хугацаатай Японы Гунма их сургуульд суралцуулахын зэрэгцээ, Австрали, Япон улсад докторантурт 2 багшийг сургаж байна.

#### **5.2.4. Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал**

- Хөтөлбөрийн багш нар сүүлийн 5 жилд гадаадад 42 удаа, дотоодод 133 удаа уртбогино хугацаагаар туршлага судалсан байна. Туршлага судлаад ирсэн багш нарын тайлан, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байдалд тэнхимийн зүгээс хяналт тавьж ажилладаг байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- АШУҮИС-ийн багшийн хөгжлийн цогц бодлогын хүрээнд багш хөгжүүлэх үйл ажиллагаа нь тогтвортой, жигд явагдаж байна.
- Хөтөлбөрийн багш нарын эрдэмжих боломжийг хангаж, сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамруулдаг, гадаадад богино хугацаагаар сургах, туршлага судлуулах ажлыг системтэй зохион байгуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- АШУҮИС-ийн багш хөгжлийн бодлогыг “Хөдөлгөөн засал” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө, биелэлтийн шалгууртай болох шаардлагатай.

### **5.3 Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

#### **5.3.1. Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо**

- Хөтөлбөрийн нийт багш нар сүүлийн 5 жилд 3 патент, 31 зохиогчийн эрх, 1 ашигтай загварын гэрчилгээ авсан байна. Ихэнх инновацийн бүтээгдэхүүн нь ерөнхий эрдмийн багш нарт хамааралтай байна. Мэргэжлийн багш нарын инновацийн бүтээгдэхүүн байхгүй.

#### **5.3.2. Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал**

- Сүүлийн 5 жилд хөтөлбөрийн мэргэжлийн багш нар “Хөдөлгөөн заслын сургалтын төхөөрөмж”, “Зүрхний шигдээсийн дараах сэргээн засалт”, “Харвалттай өвчтний хөдөлгөөн заслын эмчилгээний үнэлгээний байдал” зэрэг төсөл хөтөлбөрүүдэд оролцон ажилласан байна. Нийт 27 төсөл хөтөлбөрт оролцжээ.

#### **5.3.3. Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал**

- “Асуудалд суурилсан сургалт-3”, “Бие бялдар заслын үндэс-1”, “Хөдөлгөөн судлал” зэрэг хичээлүүдийн агуулгад “Зүрхний шигдээсийн сэргээн засалт”, “УАБӨ-ний үеийн цогц арга хэмжээ” төсөлт судалгааны үр дүнг тусгаж, сургалтын болон гардан үйлдлийн шалгалтын үнэлгээний удирдамж болгон оруулсан байна.

#### **5.3.4. Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал**

- Хөтөлбөрийн нийт багш нар сүүлийн 5 жилд үндэсний хэвлэлд 246, олон улсын хэвлэлд 18 бүтээл, IF-тай сэтгүүлд 11 эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нарын эрдэм шинжилгээ судалгааны ажил чанаржиж IF-тай сэтгүүлд нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн тоо нэмэгдсэн байна.

#### **5.4 Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

##### **Үзүүлэлт нотолгоо:**

#### **5.4.1. Өөрийн үнэлгээний тайлан**

- АШУҮИС-ийн “Багшийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу багш бүр өөрийн үнэлгээний тайланг ажилласан жилээс хамааран бичиж, Багшийн хөгжлийн зөвлөлөөр үнэлүүлдэг байна. Тухайлбал, дадлагажигч багш жил тутам, багш, ахлах багш, дэд профессорын албан тушаалд ажиллаж буй бол 3 жил тутам, 15 жилээс дээш ажиллаж байгаа бол 5 жил тутам өөрийн үнэлгээний тайланг боловсруулж нотлох баримтын хамт үнэлүүлснээр хөдөлмөрийн гэрээг сунгах, цуцлах үндэслэл бүрддэг байна. Сүүлийн 5 жилд хөтөлбөрийн мэргэшүүлэх чиглэлийн 9 багш өөрийгөө 75-95 оноо, дундажаар 92 оноогоор үнэлжээ.

#### **5.4.2. Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/**

- Сүүлийн 5 жилд мэргэшүүлэх чиглэлийн багш нар 2 удаа АШУҮИС-ийн аттестатчилалд хамрагдсан байна. Үнэлгээний хувьд дундажаар 80,581 оноотой байна.

#### **5.4.3. Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүнг, үр нөлөөний судалгаа**

- Семинар, дадлагын хичээлд ашигладаг арга зүйн үр дүнг төгсөлтийн шалгалт, төгсөгчдийн ажил эрхлэлттэй холбон авч үзсэн байна. Тайлан болон ярилцлагаар багшлахуйн арга зүйн судалгаа, хичээлийн судалгааны талаар нарийвчилсан мэдээлэл тодорсонгүй.

#### **5.4.4. Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал**

- Багшийн аттестатчилал буюу хөндлөнгийн үнэлгээний дүнгээс үүсэх хариуцлагын үр дагаварыг мөрдөн ажиллаж байна. Харин багшийн өөрийн үнэлгээний тайлан, хичээлийн судалгаа, үзүүлэх, нээлттэй хичээлийн хэлэлцүүлэг зэргийг хөтөлбөрийг хөгжүүлэхэд хэрхэн ашиглаж байгаа талаар мэдээлэл тодорхойгүй.

#### **5.4.5. Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх**

- АШУҮИС-ийн Төгсөлтийн өмнөх сургалтын албанаас UNIMIS программ ашиглан улирал бүр сэтгэл ханамжийн судалгаа авч хэвшсэн байна. Нийт 13 асуулгаар сэтгэл ханамжийн судалгаа авдаг. Үнэлгээний дүнг задлан шинжлээгүй, харьцуулалтгүй учир хөтөлбөрийг хөгжүүлэхэд ашигладаг эсэх нь тодорхойгүй.

#### **5.4.6. Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал**

- Багш бүр аттестатчиллын хүрээнд баримт бичгээ цэгцэлж, тэнхимд байршуулсан байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- АШУҮИС-ийн “Багшийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу багш бүр өөрийн үнэлгээний тайланг ажилласан жилээс хамааран бичиж, Багшийн хөгжлийн зөвлөлөөр үнэлүүлдэг.

## Анхаарах асуудал:

- Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүнд, үр нөлөөний судалгаанд ажил олгогч, төгсөгчдийг оролцуулан хичээлийн судалгаа хэлбэрээр зохион байгуулахад анхаарах.

## 5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

## Шалгуур 6. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### 6.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### Үзүүлэлт нотолгоо:

#### 6.1.1. Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ ба агуулгын харьцуулсан шинжилгээ

- Хөдөлгөөн засал хөтөлбөр нь 2012, 2014, 2016 онуудад шинэчлэгдсэн байна. Тухай бүр ажил олгогч, төгсөгчид, Монголын бие бялдар, хөдөлгөөн заслын холбоо, төрийн, ТББ-тай санал солилцож, хөтөлбөрийн сургалтын нэгдсэн төлөвлөгөө, хичээлийн агуулгаад өөрчлөлт хийдэг нь бодит баримтуудаас харагдаж байна. Тухайлбал, “Бие бялдар заслын үндэс” хичээлийн агуулгад цахилгаан эмчилгээний тухай агуулгыг нэмж, дадлагын цагтай болгосон байна. 2016 оны хөтөлбөрийн шинэчлэлээр “Асуудалд суурилсан сургалт” нэртэй 4 хичээлийн нэршлийг агуулгад нь нийцүүлж өөрчилсөн байна.

#### 6.1.2. Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал

- Сургалтын агуулгыг цогц чадамжид суурилсан мэдлэг, чадвар, хандлагаар илрэх 69 дэд бүлэг бүхий үр дүнтэй харгалзуулсан матриц үүсгэснээр хичээлийн агуулга илүү тодорхой, давхардалгүй, цэгцэрсэн байна.

#### 6.1.3. Суралцагч хичээл, багшийг сонгон суралцагч байдал чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

- Суралцагчид хөтөлбөрийн 122 багц цагийн хичээлээс 6 нэр төрлийн 12 багц цагийг сонгон судалж байна. Ангийн системээр хичээллэж байгаа тул багшийг сонгох боломжгүй.

#### 6.1.4. Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал

- Хөтөлбөрийн хичээлүүд нь онол практикийн зохистой харьцааг хангахуйц хэлбэрээр явагддаг. Тухайлбал, хичээл бүр лекц, дадлага, бататгах цаг, бие даалтын цагаас бүрдэж байна. Хичээлийн хэлбэрт ногдох цагийг тооцож үзвэл 25 хувь нь онол, 75 хувь нь практик сургалтад ногдож байна. Харин зарим хичээлийн онолын агуулга хэт их, заслын чиглэлийн дадлага дутуу харагдаж байна. Тухайлбал, Хэл заслын хичээлийн агуулгын дийлэнхид өгүүлэх эрхтний эрүүл болон эмгэг анатоми физиологийн мэдээллийг түлхүү оруулсан, өгүүлэх эрхтний дасгал, авиа тавилт, зүгшруулэлтийн процессыг орхигдуулсан байна.

#### 6.1.5. Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал

- Хөдөлгөөн засал хөтөлбөр нь эмнэл зүйн дадлага, үнэлгээний дадлага, эмчилгээний дадлагаар үр чадвар олгодог. Бүх төрлийн дадлагууд албажсан удирдамжтай. Удирдамжийг ISO 9001-2015 стандартын үйл явцын зураглал Y70-ын дагуу боловсруулсан. Мөн дадлагажигчийн тэмдэглэлийн загвар, үнэлгээний хуудасны загварыг сургалтад нэвтрүүлсэн байна. Дадлагын сургалтыг дүүргийн нэгдсэн эмнэлэг, тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэг, ШУГТЭ зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээний үндсэн дээр хөдөлгөөн засалч мэргэжилтнүүдээ түшиглэн зохион байгуулж байна.

#### **6.1.6. Зайны болон цахим хичээлүүдийг E- контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал**

- Зүрхний шигдээсийн сэргээн засах эмчилгээний интерактив хичээл, уушигны архаг бөглөрөлтийн үеийн хөдөлгөөн засал эмчилгээний цахим хичээлүүдийг боловсруулан сургалтад ашиглаж байна.

#### **6.1.7. Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал**

- Хөтөлбөрийн хичээлүүдийг агуулгын залгамж холбоонд нь индексжүүлж, ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүдийн түвшинд өмнөх дараах, зэрэгцээ холбоог тодорхойлсон байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл:**

- Хөтөлбөрийн хичээлүүд нь онол практикийн зохистой харьцааг хангахуйц хэлбэрээр явагддаг. Тухайлбал, хичээл бүр лекц, дадлага, бататгах цаг, бие даалтын цагаас бүрдэж байна. Хичээлийн хэлбэрт ногдох цагийг тооцож үзвэл 25 хувь нь онол, 75 хувь нь практик сургалтад ногдож байна.

##### **Зөвлөмж:**

- Хэл заслын хичээлийн агуулгын дийлэнхид өгүүлэх эрхтний эрүүл болон эмгэг анатоми физиологийн мэдээллийг тэнцвэржүүлж, өгүүлэх эрхтний дасгал, авиа тавилт, зүгшрүүлэлтийн процессыг тухайн хичээлийн агуулгад нэмэх шаардлагатай.

#### **6.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

##### **Үзүүлэлт нотолгоо:**

#### **6.2.1. Сургалтын арга зүйг боловсруулсан баримт бичиг, загвар**

- Сургалтын арга зүйг алхамчилсан байдлаар ISO 9001-2015 стандартын үйл явцын зураглал Y30, Y60, Y10-ыг ашиглан загварчилсан байна. Сургалтад SPICES-T загварыг нэвтрүүлж шавь төвтэй, асуудалд суурилсан, нэгдмэл агуулгатай, нийгэмд тулгуурласан, бүхэллэг тогтолцоо бүхий багаар хамтран ажиллах арга зүйг ашиглаж иржээ.

#### **6.2.2. Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал**

- Хөтөлбөрт ашиглаж буй SPICES-Тарга зүйг багш нар оновчтой ашиглаж байгаа нь суралцагчдын гардан үйлдлийн үзүүлэх дасгалаар тодорхой харагдаж байлаа. Сургууль дээр ажиллах явцад оюутнуудтай уулзах уулзалтаар 3,4 дүгээр дамжааны суралцагчид Үүдэн эмнэлэгт өөрсдийн эзэмшсэн чадамжуудаа эмнэл зүйн тодорхой тохиолдолд хэрэглэж харуулсан болно.

#### **6.2.3. Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа**

- Хөдөлгөөн заслын дадлагын ор, судалгааны өндөр хурдны камер, нэг бүрийн хэмжилт, үнэлгээний багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байна.

#### **6.2.4. Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал**

- Сургалтын арга зүйн үнэлгээг 17/18 оны хичээлийн жилд Хөдөлгөөн засал хөтөлбөрийн 57 оюутнаас авсан байна. Асуулгыг мэргэжлийн хичээлийн агуулгатай уялдуулан боловсруулжээ. Гэвч асуулга сургалтын арга зүйг үнэлэхэд учир дутагдалтай, зөвхөн агуулгын хүрээнд эргэлдсэн байдалтай байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**



- Хөтөлбөрт ашиглаж буй SPICES-T арга зүйг багш нар оновчтой ашиглаж байгаа нь суралцагчдын гардан үйлдлийн үзүүлэх дасгалаар тодорхой харагдаж байлаа. Сургууль дээр ажиллах явцад оюутнуудтай уулзах уулзалтаар 3,4 дүгээр дамжааны суралцагчид Үүдэн эмнэлэгт өөрсдийн эзэмшсэн чадамжуудаа эмнэл зүйн тодорхой тохиолдолд хэрэглэж харуулсан болно.

### **6.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

**Үзүүлэлт нотолгоо:**

#### **6.3.1. Мэдлэг, урчадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ**

- Хичээл бүрээр эзэмших цогц чадамжийн хүрээг тодорхойлж, аман, эссэ бичлэг, цахим сорил, эмнэл зүйн тохиолдлын сорилоор мэдлэгийн хүрээг үнэлдэг байна.
- Ур чадварыг өртөөлчилсөн шалгалт, урт богино хэлбэрийн эмнэл зүйн тохиолдол, гардан шалгалт, өвчтний менежментийн шалгалтаар үнэлдэг байна.
- Цогц чадамжийг бүхэлд нь портфель үнэлгээ, гардан гүйцэтгэлийнажиглалт, эмнэл зүйн дасгал, 360 хэм үнэлгээ зэргээр үнэлж байна.
- Мөн ажил олгогчоос сэтгэл ханамжийн судалгаа авч, суралцагч төгсөгчдийн ур чадварыг үнэлүүлж хэвшсэн байна.

#### **6.3.2. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал**

- Цогц чадамжид тулгуурласан мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээг хичээл бүрт нэвтрүүлж, суралцагчийн гардан үйлдэл, үйлдлийн онолын үндсийг тодорхойлох мэдлэгийг нь баяжуулан ажиллаж байна. Төлөвлөгдсөн зорилготой гардан шалгалтын гарын авлагаар дамжуулан суралцагчдын ур чадварыг хөгжүүлж байна.

#### **6.3.3. Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал**

- Оюутан бүр UNIMIS программаас сурлагын дүнгээ нээлттэй үзэх боломжтой. 2 дугаар улирлын эхэнд дүнгийн асуудлыг хэлэлцэн анги удирдсан багш нар хяналт тавьж ажилладаг байна. Сорилын шалгалтуудын найдварт чанарыг тогтмол үнэлэн сайжруулж байна.

#### **6.3.4. Суралцагчийн гаргаж буй амжилтууд**

- Суралцагчид 3,6 голч онооноос дээш үзүүлэлтээр онцлох дипломтой төгсдөг, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн чансаагаараа Сувилахуйн сургуулийн бусад хөтөлбөрөөс тэргүүлж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл:**

- Цогц чадамжид суурилсан сургалтын арга зүй, үнэлгээний тогтвортой бодлоготой, мэдлэг, чадвар, хандлагын түвшинг тодорхойлох өвөрмөц аргуудыг тогтмол хэрэглэж байна.

**Анхаарах асуудал:**

- Блум таксономийн онолоор мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээг рубрикийн аргаар хийж хэвшихэд анхаарах

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 7. Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө**

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

## **7.1. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

### **Үзүүлэлт нотолгоо:**

#### **7.1.1.Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал**

- АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль нь 2017 оноос ISO 9001:2015 “Чанарын удирдлагын тогтолцоо”-г хэрэгжүүлж эхлэн төгсөгчдийн ажил эрхлэлт, сэтгэл ханамж, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж байна. Хөдөлгөөн засалч хөтөлбөрөөр төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг 2018 оны3-р сарын байдлаархийсэн судалгаанаас харахад нийт 128 хөдөлгөөн засалч төгссөнөөс Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин 93% буюу нийт 119 хөдөлгөөн засалч улсын төв эмнэлгүүд, мэргэжлийн үндэсний төвүүд, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд, улсын болон хувийн сувилал, эмнэлгүүд, боловсролын байгууллагуудад ажиллаж байна.
- Үргэлжлүүлэн гадаад, дотоодын их дээд сургуулиудад магистр, докторын сургалтад хамрагдаж байгаа 8 төгсөгч байгаа нь нийт төгсөгчдийн 6.25%-ийг эзэлж байна. Төрсөн гэсэн шалтгаанаар 6 хөдөлгөөн засалч ажил эрхлээгүй байгаа бөгөөд нийт төгсөгчдийн 4.7%-ийг эзэлж байна. Эдгээр нь 2016 оноос хойш төгссөн төгсөгчид байгаа нь харагдаж байна.
- Хөдөлгөөн засалч хөтөлбөрөөр 2011 оноос хойш нийт төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг харахад улсын төв эмнэлэгт 29, мэргэжлийн үндэсний төвд 24, дүүргийн нэгдсэн эмнэлэгт 15, аймгийн нэгдсэн эмнэлэгт, боловсролын байгууллагад 9, их дээд сургуульд багш 3, хувийн эмнэлэгт 28, сувилалд 7, сурч байгаа 8, ажилгүй 9 тус тус ажиллаж байна.

#### **7.1.2. Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа**

- Төгсөгчдөөс авсан сэтгэл ханамжийн судалгааны дүнг нэгтгэн харвал: Төгсөгчдийн 97.6% эзэмшсэн мэргэжилдээ сэтгэл ханамжтай, 96.6% эзэмшсэн мэдлэг, чадвар нь ажлын байрны шаардлагыг хангаж байгаа гэж хариулсан байна. Мөн төгсөгчдийн 92.9% сургуулиа төгсөөд ажил олоход хэцүү байгаагүй гэж хариулсан нь ажлын байр олдоц сайтай бөгөөд хөдөлгөөн засалч мэргэжилтний хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.
- Судалгаанд хамрагдагсдын 2.4% эзэмшсэн мэргэжилдээ сэтгэл ханамж дунд зэрэг, 3% эзэмшсэн мэдлэг, чадвар нь ажлын байрны шаардлагыг бүрэн хангаж чаддаггүй гэж хариулсан бөгөөд энэ нь монгол хэл дээрх ном, сурах бичиг, гарын авлага хангалтгүй байгаатай холбоотой байна.
- Хөтөлбөрийн үр дүнгийн “гүйцэтгэлийн үнэлгээ”-гтодорхойлохын тулд сургуулийн төгсөгчдийг ажиллуулж байгаа улсын болон хувийн эмнэлгүүдийн удирдлагуудыг хамруулан судалгааг хийжээ. Судалгаанаас харахад ажил олгогчдын сэтгэл ханамжийн түвшин маш сайн болон сайн байгаа бөгөөд дунд, муу гэсэн хариулт байгаагүй.
- Хөдөлгөөн засалч мэргэжилтний мэдлэг, ур чадварыг ажил олгогчдын 94% маш сайн болон сайн гэж үнэлсэн нь бэлтгэгдэж буй хөдөлгөөн заслын мэргэжлийн хөтөлбөр нь төгсөгчдөд хангалттай мэдлэг, ур чадвар эзэмшүүлж байгааг илтгэж байна. Харин 6% нь мэдээлэл, орчин үеийн техник технологийг ашиглан харилцаа холбоо тогтоох, мэдлэгийг ашиглах чадвар, манлайлах ур чадвар, аюулгүй байдлыг хангаж ажиллах чадвар дутмаг гэж тодорхойлсон байна.
- Цаашид хөдөлгөөн засалч мэргэжилтнийг авч ажиллуулах сонирхолтой байна гэж нийт ажил олгогчдын 94.1% нь хариулсан байгаа нь мөн л хөдөлгөөн засалч мэргэжилтний хэрэгцээ шаардлага байгааг дахин нотлон харуулж байна.

### 7.1.3. Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацаа

- Хөдөлгөөн засалчдын хувьд 54% нь төгссөний дараа 1 сарын дотор, 23% нь 3 сарын дотор, 12% нь 6 сарын дотор ажилд орсон байна. 11% нь төгссөний дараа хүүхэд төрүүлсэн, гадаад явсан зэрэг шалтгаанаар 1-4 жилийн дараа ажилд оржээ.

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог:

- Тус хөтөлбөрөөр Монгол улсад анх удаа хөдөлгөөн засалч мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн.

#### Анхаарах асуудал:

- Оюутнуудын гадаад хэлний ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах

#### Зөвлөмж:

- Орон нутгийн захиалгаар хөдөлгөөн засалч бэлтгэх,
- Цаашид хөдөлгөөн засалч мэргэжлээр төгсөгчдийн тоог нэмэгдүүлэх
- Эмнэлзүйн дадлагыг түлхүү оруулах

### 7.2. Хөтөлбөрийн үр нөлөө:

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

#### Үзүүлэлт нотолгоо:

##### 7.2.1. Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд

- Салбар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь
- Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр /Төрийн болон ТББ-ын зүгээс хийсэн үнэлгээ, судалгаа/

##### 7.2.1. Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилт

- 2007 онд ЭМШУИС (одоогийн АШУҮИС) болон Японы Гунма Их Сургуулийн хооронд хамтын ажиллагааны гэрээ байгуулагдсан нь бакалаврын боловсролтой Хөдөлгөөн засалч мэргэжилтэн бэлтгэх суурь тавигдсан бөгөөд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн хувьд Монгол улсад **анх удаа** хөдөлгөөн засалч мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн байна. 2011 оны 5 сард анхны төгсөлтөө амжилттай хийснээр эрүүл мэндийн салбарт эзлэх сэргээн засах тусламж үйлчилгээний байр суурийг нэмэгдүүлж, түүний мөн чанарыг ард олон, эмнэлгийн бусад мэргэжилтнүүдэд таниулахад илэрхий түлхэц болсон.
- Монгол улсад 2013 оны 11 сард 1 магистр, 2018 оны 3 сард 1 магистр АШУҮИС-д хамгаалсан. Докторантурын сургалтанд 2014 оноос Монгол улсад 1, 2018 оноос Япон улсад 1 төгсөгч хамрагдан суралцаж байна.
- АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн Бие бялдар судлалын тэнхимд дадлагажигч багшаар 2012 болон 2015 оноос ажиллаж эхэлсэн 3 төгсөгч маань тодорхой шалгуур, шаардлагыг хангасны үндсэн дээр дадлагажигч багшаас багш, тэнхимийн эрхлэгч болон тушаал дэвшин боловсролын салбарт өөрийн хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

##### 7.2.2. Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр

- 2011-2017 оны хооронд хөдөлгөөн засалч мэргэжлээр төгсөгчдийн тооноос харахад эхний 4 жилд 12-16 мэргэжилтэн төгсөж байсан ба 2015 оноос 26 хүртэл өссөн байна. Дараагийн жилүүдэд тогтмол өсөлттэй харагдаж байна. Хүснэгтээс харахад 2011 оны 7 сараас анхны мэргэжилтнүүд эрүүл мэндийн салбарт ажиллаж эхэлсэнтэй зэрэгцээд 2011 оны 9 сараас энэ мэргэжлээр элсэгчдийн тоо хоёр дахин нэмэгдсэн харагдаж байна.
- Төгсөгчдөөс эрдмийн зэрэг хүртсэн судлаачид хөдөлгөөн заслын тусламж үйлчилгээний арга, мөн чанар зэргийг орчин үеийн шинжлэх ухааны аргуудаар судлан тайлбарлах ажилд хувь нэмрээ оруулж байна.

- Гунма их сургуультай хамтран хөдөлгөөн засалч нарын судалгаа эрдэм шинжилгээний ажлыг дэмжин 6-11 сараар 4 хөдөлгөөн засалч суралцаж судалгааны ажлаа Гунма их сургуульд хийж гадаадын нэр хүнд бүхий сэтгүүлд хэвлүүлэх хүсэлтээ хүргүүлээд байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог:**

- Төгсөгчдийн 5.5% нь эрдмийн зэрэг хамгаалах сургалтад хамрагдаж байгаагаас 43% дотоод болон гадаадын их сургуульд магистрын зэрэг хамгаалжээ.
- Тархины харвалтын сэргээн засахын удирдамж”, “Зүрхний шигдээсийн сэргээн засахын удирдамж”-д *хөдөлгөөн засалч* нь сэргээн засах эмчилгээний багийн гишүүн болохыг тодорхойлсон.
- Эрүүл мэндийн тухай хууль”-д 8 заалтад сэргээн засах тусламж үйлчилгээтэй холбоотой өөрчлөлт оруулсан.

#### **Анхаарах асуудал:**

- Мэргэжлийн танилцуулгыг олон нийтэд сурталчилан таниулах, Зах зээлийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх
- Мэргэжлийн үнэлэмжийг сайжруулах

#### **Зөвлөмж:**

- Хөдөлгөөн засалч мэргэжлээр төгсөгчдийг төрөлжсөн сургалтад хамруулах

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### **Үзүүлэлт нотолгоо:**

##### **7.3.1. Суралцаж буй гадаад оюутны тоо**

- Одоогоор АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн Хөдөлгөөн заслын бакалаврын сургалтад хамрагдаж, бүтэн суралцаж байгаа гадаад оюутан байхгүй хэдий ч 2009 оноос хойш Японы Гунма их сургуулиас богино хугацааны оюутан солилцоогоор ирж суралцсан 37 оюутан байна. Цаашид бакалаврын сургалтад гадаад оюутан хамруулах төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

##### **7.3.2. Олон улсын хамтарсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт**

- АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн Бие бялдар судлалын тэнхим нь Японы Гунма их сургуультай 2007 оноос эхлэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, шинэчлэх, багш, оюутан солилцоо болон хамтарсан төсөл хэрэгжүүлж байна.
- Багш солилцоогоор Японы Гунма их сургуульд очиж урт болон богино хугацаагаар туршлага судалж сургалтад хамрагддаг.
- Оюутан солилцоогоор Сувилахуйн сургуульд ирж суралцсан болон, Гунма их сургуульд очиж суралцсан.
- Бие бялдар судлалын тэнхимийн багш Б.Мөнх-Эрдэнэ, Г.Намуун нарын оролцсон Монгол улсад “Хөдөлгөөн засал” хөтөлбөр амжилттай хэрэгжиж байгаа талаар [“Journal of Physical Therapy Education”](#) сэтгүүлд өгүүлэл хэвлэгдсэн.
- Мөн бие бялдар судлалын тэнхимийн эрхлэгч Д.Батлхам, Гунма их сургуулийн профессор Rie Nakazawa, Masaaki Sakamoto нартай хамтарсан *“The relationship between the exercise tolerance and trunk posture”* сэдэвт өгүүлээ [“Journal of Physical Therapy Education”](#) сэтгүүлд хэвлүүлэхээр хүсэлт гаргасан бөгөөд, тухайн сэтгүүлээс хүсэлтийг хүлээж авсан хариу ирсэн.
- Японы Гунма их сургуулийн төгсөлтийн дараах сургуулийн хөдөлгөөн заслын докторант, магистрант, АШУҮИС-ын хөдөлгөөн заслын докторант, магистрантуудын хамтарсан “МОНГОЛ УЛС ДАХЬ ЧИХРИЙН ШИЖИН ӨВЧНИЙ

ЭМЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХИ АСУУМЖ СУДАЛГАА” 2016 оны 01 сараас эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар судалгааны ажил төгсгөлийн шатандаа орж “Journal of Physical Therapy Education” сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх хүсэлтээ хүргүүлсэн.

### 7.3.3 Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт

- Хөдөлгөөн засалч мэргэжлээр төгсөгчдийн улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилтыг доорх хүснэгтээр харуулсан байна.

#### Хөдөлгөөн засалч хөтөлбөрөөр төгсөгчдийн эрдэм шинжилгээ, амжилт

№	Нэрс	Ажилладаг байгууллага	Шагнал	Хэдэн оны төгсөлт
1	Д.Батлхам	АШУҮИС	- Шилдэг багш-2016	2011
2	Нарантуяа	Оргил рашаан сувилал	- 2017 оны байгууллагын шилдэг ажилтан	2013
3	Г.Ариунзаяа	СЦЯ-ын 10-р цогцолбор	- 2015 оны байгууллагын шилдэг ажилтан	2011
4	Оюунгэрэл	ЧДЭМН	- 2016 оны байгууллагын эрдэм шинжилгээний “Судлаач-7” хуралд “С4-С5 түвшний хугарлын дараах хөдөлгөөн засал эмчилгээний үр дүн”, “Цус харвалтын дараа сувилахуйн асаргаа сувилгаа болон хөдөлгөөн засал эмчилгээний үр дүн” сэдэвт илтгэлээр тэргүүн байр	2015
5	Ариунномин	Натул эмнэлэг	- 2016 оны байгууллагын шилдэг тусгай мэргэжилтэн - 2016 онд “Тархины саажилттай хүүхдийн хөдөлгөөн заслын үр дүн” 1-р байр - 2016 онд “Хөдөлгөөн засал ба TENS эмчилгээний үр дүн” 3-р байр	2015
6	Өнөр-Аюуш	Зүүнхараа ЭМН	- 2017 онд эрдэм шинжилгээний хурлаар 1-р байр - 2016 онд хамгийн их талархал хүлээсэн тусгай мэргэжилтэн	2013
7	Тажгүль	ХУЭМТ	- 2016 онд ХУЭМТ-ийн “Бүсэлхий нурууны өвдөлтийн үе дэх хөдөлгөөн засал эмчилгээ” 1-р байр - Эрүүл мэндийн төвийн шилдэг 10 илтгэлийн 1	2015
8	М.Ойров	ШУГТЭ	- Зүрх судасны төвийн үндэсний конференци-2015 эрдэм шинжилгээний хуралд “Зүрхний шигдээсийн дараах эмнэлэгт суурилсан 4 долоо хоногийн хөдөлгөөн засал эмчилгээний үр дүн” шилдэг илтгэл - 2016 онд ШУГТЭ-ийн өсөх ирээдүйтэй тусгай мэргэжилтэн	2013
9	Б.Лхамхүү	СЗҮТ	- 2015 онд байгууллагын шилдэг ажилтан - 2015 онд “Хөдөлгөөн засал эмчилгээг хугацаанаас хамааран үр дүнг судлах” 1-р байр - 2015 онд чанарын албаны эмчилгээний чанарыг сайжруулах нь уралдааны 3-р байр	2013
10	Л.Гэрэлцэцэг	Геронтологийн үндэсний төв	- 2013 онд байгууллагын шилдэг ажилтан - 2013 онд “Насжилт настны сэргээн засалт ” хуралд 2-р байр - 2015 онд Хөдөлмөрийн алдар медалиар шагнагдсан. - 2015 онд International conference on Gerontology and geriatrics ulaanbaatar-2015 олон улсын хуралд илтгэлээр тусгай байр - 2016 онд эрчүүдийн эрүүл насжилт олон улсын хуралд 1-р байр	2013
11	Г.Ганцэцэг, Г.Туул	УНТЭ	- 2015 онд УНТЭ, Мэс заслын салбар нийгэмлэгийн эрдэм шинжилгээний хуралд “Өвдөгний үе солиулах	2011

			хагалгааны дараах хөдөлгөөн засал эмчилгээний үр дүн” сэдвээр дэд байр	
12	Г.Болормаа	УХТЭ	- 2014 онд байгууллагын шилдэг ажилтан - 2014 онд байгууллагын эрдэм шинжилгээний хуралд “Уушгины архаг бөглөрөлтөт өвчний үеийн хөдөлгөөн засал эмчилгээ” сэдэвт илтгэлээр 3-р байр	2011

- Нийт төгсөгчдийн 9.4% улсын болон байгууллагын чанартай эрдэм шинжилгээний хуралд шалгарч байр эзэлсэн байна.

#### 7.3.4. Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

- Төгсөгчид нь Японы Гунма их сургууль, Солонгосын Сөүлийн үндэсний их сургуульд магистрантур, докторантурын сургалтанд хамрагдаж, эрдмийн зэргээ амжилттай хамгаалж, хамтарсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.
- 2011 оноос хойш нийт төгсөгчдийн 3.1% нь магистрын зэрэг хамгаалсан байна. Тэдгээрийн 50% нь магистрын зэргээ олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт хамрагдан Япон улсад суралцаж хамгаалсан байна.
- 2018 оны 3 сарын байдлаар Япон, Солонгос зэрэг гадаадын өндөр хөгжилтэй оронд үргэлжлүүлэн суралцаж байгаа 4 төгсөгч байгаагаас 25% нь докторантурын сургалтад, 75% нь магистрантурын сургалтад хамрагдаж байна. Үүнээс харахад гадаадын өндөр хөгжилтэй орнуудад үргэлжлүүлэн суралцаж буй суралцагч нийт төгсөгчдийн 3,1%-ийг эзэлж байгаа нь жилээс жилд гадаадад магистр, докторын сургалтад элсэн суралцах суралцагчийн тоо өсөн нэмэгдэж байгааг харуулж байна.

#### 7.3.5. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн байдал

- 2012 онд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн Бие бялдар судлалын тэнхимийн багш нар болон Хөдөлгөөн заслын бакалаврын хөтөлбөрөөр төгсөгчдийн нэгдсэн уулзалтаар Монгол Бие Бялдар Хөдөлгөөн заслын холбоог (МБХЗХ) үүсгэн байгуулсан байна.
- 2014 оны 10 сарын 15-ны өдөр МБХЗХ-г ДХЗХ-ны албан ёсны гишүүнээр хүлээн зөвшөөрсөн. 2015 оны 4 сарын 29-нд Сингапур улсад зохион байгуулагдсан ДХЗХ-ны 18-р чуулганы үеэр Монгол Бие Бялдар Хөдөлгөөн заслын холбоог ДХЗХ-ны албан ёсны гишүүнээр элсүүлсэн тухай зарлан, батламж олгосон байна.

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

##### Онцлог зүйл:

- Олон улсын хурлыг жил бүр тогтмол зохион байгуулдаг

##### Анхаарах асуудал:

- Гадаад оюутнуудын тоог нэмэгдүүлэх /элсүүлэх/

##### Зөвлөмж:

- Олон улсын нэр хүндтэй сэтгүүлд хэвлүүлэх бүтээлийн тоог нэмэгдүүлэх
- Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг нэмэгдүүлэх

#### 7.4. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

##### Үзүүлэлт нотолгоо:

#### 7.4.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал

- Жил бүрийн 9-р сарын 8-нд болдог “Дэлхийн хөдөлгөөн засалч нарын өдөр”-ийг Монгол улсад анх 2013 оноос хойш тэмдэглэж ирсэн. Тухайн өдрөөр улсын 3-р шатлалын болон дүүргийн эмнэлгүүдээр хөдөлгөөн засал мэргэжлийг сурталчлан сургалт болон хөдөлгөөн заслын эмчилгээнд ашиглагддаг гардан үйлдлийн техникийн сургалт явуулж ирсэн.

- 2015 оноос хойш АШУҮИС, Сувилахуйн сургуулийн Бие бялдар судлалын тэнхимийн багш нар нь ЛСА олон улсын байгууллагын ажилчидтай хамтран жил бүр “БАГШ ШАВИЙН УУЛЗАЛТ”-ыг хөдөө орон нутгаар зохион байгуулж байна.

#### 7.4.2. Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

- Олон нийтийг үнэн зөв, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр хангахын тулд [АШУҮИС-ийн цахим хуудсанд](#) Бие Бялдар Судлалын тэнхимийн танилцуулга, багш нарын танилцуулга болон үйл ажиллагааны мэдээллийг байршуулсан.

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

##### Онцлог зүйл:

- Жил бүр хөдөлгөөн заслын өдрийг тэмдэглэдэг
- Багш шавийн уулзалтыг орон нутагт ажиллаж байгаа төгсөгчтэй хамтран зохион байгуулдаг.

##### Зөвлөмж:

- Тэнхимийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг сургуулийн вэб сайтанд тогтмол оруулж, шинэчилж байх

#### 7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

### Шалгуур 8. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

#### 8.1. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.

##### Үзүүлэлт нотолгоо:

#### 8.1.1. Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуултыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үр дүн

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтыг хангахын тулд Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001 олон улсын стандартын шаардлагын дагуу дотоод аудитын багийг томилох, сургах, ажиллуулах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.
- АШУҮИС-ийн хөтөлбөрийн хороо нь сургалтын хөтөлбөр боловсруулах, шинэчлэх, хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн болон чанарын удирдлагаар хангаж, үр дүнг тооцох үүрэгтэй ажилладаг байна.

#### 8.1.2. Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ

- Сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн журмын дагуу мэргэжлийн тэнхим ажлын хэсэг, баг зөвлөл нь Сургалтын бодлого зохицуулалтын газраас баталгаажуулсан загварын дагуу цогц чадамжид тулгуурлан сургалтын хөтөлбөрийг боловсруулдаг байна. Хөдөлгөөн засалч хөтөлбөр хэрэгжүүлж эхэлснээс хойш 5 удаа шинэчилж боловсронгуй болгох, сайжруулах ажлыг хийсэн байна.

#### 8.1.3. Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо

- Чанарын удирдлагын тогтолцооны үйл ажиллагааг тогтмолжуулж чанарыг сайжруулах үүднээс хөтөлбөрийн оролцогч талууд, хэрэглэгчээс сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэлт хийж ажиллаж байна. Тухайлбал: хичээлийн хөтөлбөр агуулгад 85,6%, хичээлийн үзүүлэн хэрэглэгдхүүнд 80,4%, багшийн ур чадвар, харилцаа хандлагад 87,4% сэтгэл ханамж сайтай байгаа бол анги танхимийн хүрэлцээ хангамжид 79,2% байгаад үндэслэн өрөө тасалгаа, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах шийдвэр гаргасан байна.

#### 8.1.4. Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг хийдэг байдал

- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхэд өөрийн үнэлгээ хийж, ажил олгогчидтой чанарын судалгааны дагуу ярилцлага хийхэд ажил олгогчдын 94% нь маш сайн, сайн үнэлгээ өгсөн байна. Хийсэн ажилдаа үнэлэлт дүгнэлт өгч “Шинэ санаа, шинэ бүтээл” уриатай ажиллаж байна.

**8.1.5. Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг хөтөлбөрийн ахиц, дэвшилд системтэйгээр ашигласан байдал**

- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор төгсөгчид, ажил олгогчид, оюутнаас санал асуулга авч, тухай бүрт нь дүгнэсний үндсэн дээр ББСТ-ийн хөдөлгөөн заслын хөтөлбөрийн 2018-2023 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулсан байна.

**8.1.6. Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянасан байдал**

- 2011-2017 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж цаашид эрдэм шинжилгээ, судалгааны ажлын түвшин, үр дүнг дээшлүүлэх, багшлах боловсон хүчний тогтвортой хөгжлийг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлснээр хөтөлбөрийн үр нөлөөг сайжруулах болохыг тэмдэглэсэн байна.

**8.1.7. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд эргэх холбоо үүсгэх**

- Хөдөлгөөн засалч мэргэжлээр суралцан төгссөн төгсөгчид, ажил олгогчид нартай холбоотой ажиллаж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл:**

- Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001 олон улсын стандартын шаардлагын дагуу дотоод аудитын баг ажиллаж байна.

**Анхаарах асуудал:**

- Чанарын удирдлагын хорооноос хийсэн судалгаа, шинжилгээ, дүнгийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн ажлын биелэлтийг үнэлэх, дүгнэх

**8-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

**ДҮГНЭЛТ:**

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн “Хөдөлгөөн засал” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	+			Хөдөлгөөн засалч нь харьцангуй шинэ мэргэжил хэдий ч нийгэмд энэхүү мэргэжлийн ач холбогдолыг таниулж, эрэлт хэрэгцээг бий болгож чадсан.
2	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	+			Хөдөлгөөн заслын лабораторийг тохижуулан хөдөлгөөн заслын мэргэжлийн хичээлийн



					дадлага, семинар явуулж байна.
3	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	+			Монголын бие бялдар хөдөлгөөн заслын холбооны хүрээнд гадаад болон дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж ажиллаж байна.
4	Суралцагчдад чиглэсэн ажиллагаа үйл	+			Оюутны судалгааны ажлыг сайн дэмжиж байна.
5	Багшийн үйл ажиллагаа	+			Хөтөлбөрийн багш нарын эрдэмжих боломжийг хангаж, сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамруулдаг, гадаадад богино хугацаагаар сургах, туршлага судлуулах ажлыг системтэй зохион байгуулдаг.
6	Сургалтын үйл ажиллагаа	+			Цогц чадамжид суурилсан сургалтын арга зүй, үнэлгээний тогтвортой бодлоготой, мэдлэг, чадвар, хандлагын түвшинг тодорхойлох өвөрмөц аргуудыг тогтмол хэрэглэж байна.
7	Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө	+			Эрүүл мэндийн тухай хууль"-д 8 заалтад сэргээн засах тусламж үйлчилгээтэй холбоотой өөрчлөлт оруулсан.
8	Чанарын үнэлгээ, баталгаажилт	+			Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001 олон улсын стандартын шаардлагын дагуу дотоод аудитын баг ажиллаж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ...../Т.Алтанцэцэг /  
Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Б.Одончимэг/  
Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../М.Үүрийнтуяа/

#### IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн “Хөдөлгөөн засал” хөтөлбөрийн багш нартай хийсэн уулзалтад оролцсон багш нарын нэрс

Хугацаа: 2018.11.14, 14:00-15:00, 207 тоот өрөөнд

№	Овог нэрс	Албан тушаал	Заадаг хичээл	Гарын үсэг
1	Буяндэлгэр	Багш	Монголын түүх, соёл, ёс заншил	
2	Я.Энхжаргал	Тэнхимийн эрхлэгч, ахлах багш	Нийгмийн эрүүл мэнд	
3	Орхонтуяа	Багш	Анагаахын хими	
4	Лхагвасүрэн	Багш	Биологи	
5	Ж.Мөнхханд	Тэнхимийн эрхлэгч	Харилцааны ур чадвар	
6	Отгонбат	Ахлах багш	Анатоми 1,2	
7	Чойням	Багш	Физиолги 1,2	
8	Г.Сүхбат	Багш	Биеийн тамир	
9	Д.Батлхам	Тэнхимийн эрхлэгч, Багш	Нийгэм орчны дэмжлэг, Хөдөлгөөн судлал 1, Эмнэлзүйн бие бялдар засал 1	
10	С.Дэлгэрмаа	Ахлах багш	Сэтгэц судлал, Мэдрэл судлал	
11	Г.Түвшинбаяр	Багш	Ортепид гэмтэл	
12	Алтантуул	Багш	Клиник анагаах ухаан	
13	Х.Энхчимэг	Дадлагажигч багш	Эмнэлзүйн хөдөлгөөн судлал, Багаар ажиллах арга зүй, Эмнэлзүйн бие бялдар засал 2	
14	Г.Булганцэцэг	Дадлагажигч багш	Хэл залгиурын эмгэг, Биостатистик	
15	П.Мөнхжаргал	Цагийн багш	Бие бялдар заслын үндэс, Асуудалд суурилсан сургалт 3	

II. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн “Хөдөлгөөн засал” хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудтай хийсэн уулзалтад оролцогчдын нэрс

Хугацаа: 2018.11.14, 14:00-15:00, 207 тоот өрөөнд

№	Овог нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	Мөнхсарнай	4 курс	Сайн дурын байгуулга	99774500
2	Ариунжаргал	4 курс	Сайн дурын байгууллага	80900316
3	Дэмүүл	4 курс	Орон нутаг	98179933
4	Лхагва-Очир	4 курс	Орон нутаг	99134914
5	Тэлмэн	4 курс	Сурлага	99740744
6	Булгантамир	3 курс	Оюутны клуб	99984053
7	Баяржаргал	3 курс	Оюутны байр	89568957
8	Мөнхсайхан	3 курс	Оюутны зөвлөл	89155848
9	Нандинцэцэг	3 курс	Орон нутаг	98331962

10	Ням-Очир	3 курс	Сурлага	88169426
11	Намуунгэрэл	2 курс	Орон нутаг	90779097
12	Тулга	2 курс	Орон нутаг	99521592
13	Батням	2 курс	Сурлага	96230110
14	Энхтуул	2 курс	Оюутны кпуб	99259633
15	Сугар-Өлзий	2 курс	Оюутны байр	96970840
16	Буянхишиг	1 курс	Орон нутаг	95763992
17	Ариунбаясгалан	1 курс	Орон нутаг	89142800
18	Хулан	1 курс	Улаанбаатар	86142073
19	Телеген	1 курс	Оюутны зөвлөл	99124733
20	Энхжин	1 курс	Улаанбаатар	88128962

**Ш.АШУУИС-ийн Сувилахуйн сургуулийн “Хөдөлгөөн засал” хөтөлбөрийн ажил олгогчтой уулзах нэрс**


**Хугацаа: 2018.11.15, 10:00-11:00, 207 тоот өрөөнд**

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал	Утас	Гарын үсэг
1	О.Батгэрэл	УГТЭ-ийн эрдэм шинжилгээ, сургалт эрхэлсэн дэд захирал	99186187	
2	Цэнджав	Нийслэлийн эрүүл мэндийн газрын сэргээн засах хариуцсан мэргэжилтэн	94948327	
3	О.Золзаяа	УХТЭ-ийн сэргээн засах тасгийн эрхлэгч	99105124	
4	Цэрэндолгор	Гэмтэлийн эмнэлэгийн сэргээн засах тасгийн эмч	98110829	
5	Урангэрэл	Дал засал		
6	Золзаяа	Натул	88861060	
7	Алтанцэцэг	Эрүүл мэндийн хөгжлийн 99077976 төв, мэргэжилтэн	99077976	
8	Ш.Батчимэг ИСНЭ-ийн сэргээн засах 99098957	ИСНЭ-ийн сэргээн засах тасгийн эрхлэгч	99098957	
9	Амаржаргал	ЭХЭМҮТ, эмэгтэйчүүдийн эмнэлэг, сэргээн засахын тасгийн эрхлэгч		
10	Соёлмаа	Мөнгөн гүүр эмнэлэг, Сэргээн засах тасгийн эрхлэгч	99046091	
11	Гэрэл	ЧДЭН, Сэргээн засах 98866860 тасгийн эрхлэгч	98866860	
12	Г.Уянга	БГДЭН	91000343	
13	Ганхүү	Грандмед, Сэргээн засах 88074551 тасгийн сэргээн засалчэмч	88074551	
14	Болорчулуун	Таны инээмсэглэл 88110615	88110615	

**IV. АШУУИС-ийн Сувилахуйн сургуулийн “Хөдөлгөөн засал” хөтөлбөрийн төгсөгчдийн төлөөлөлтэй хийсэн уулзалтад оролцогчдын нэрс  
Хугацаа: 2018.11.15, 11:00-12:00, 207 тоот өрөөнд**

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас	Гарын үсэг
1	Г.Ганцэцэг	2011	УНТЭ, Хөдөлгөөн засалч	88000224	
2	Б.Золбоо	2011	Саажилттай хүүхдийн 10-р цэцэрлэг	99036938	
3	Г.Номин- Эрдэнэ	2012	ОБЕГ-ын харьяа ДССЗтөв	89010127	
4	Болорчимэг	2012	ЭХЭМҮТ, Хөдөлгөөн засалч	99443680	
5	М.Ойров	2013	УГТЭ, Хөдөлгөөн засалч	99185939	
6	Б.Цэнгүүн	2013	Интермед эмнэлэг	89909174	
7	Цолмонбаяр	2014	ХСҮТ, Хөдөлгөөн засалч	95967733	
8	Ганцэцэг	2014	УХТЭ, Хөдөлгөөн засалч	95136019	
9	Лхагвасүрэн	2015	УГТЭ-ийн Хөдөлгөөн засалч	99490342	
10	Оюунгэрэл	2015	ЧДЭМН, Хөдөлгөөн засалч	99420372	
11	Оргил	2016	Дал засал	99965154	
12	Р.Рэнцэнханд	2016	Дал засал эмнэлэг, Хөдөлгөөн засалч	99342979	
13	Г.Ганчимэг	2017	Зинт кпиник, Хөдөлгөөн засалч	88074445	
14	Баярсүрэн	2017	Сэргээн засах кпиник	99662113	
15	Э.Баасанхүү	2018	Мөнгөн гүүр эмнэлэг	88683803	
16	Дуламбат	2018	ХУДНЭ, Хөдөлгөөн засалч	94696946	

# Ү.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал /албан бичгийг оруулах/



**АШУУИС** | СУВИЛАХУЙН СУРГУУЛЬ  
Ангийн Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6-р хороо,  
Ард Аюушийн гудамж,  
Улаанбаатар-26 салбар, 188-р шуудангийн хайрцаг,  
И-мэйл: nursing@mnuims.edu.mn, Веб: nursing.mnuims.edu.mn  
Утас: 70007633, Факс: 976-70007633

2018.12.06 № 01/136  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН  
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ  
ЗӨВЛӨЛД

Тайлангийн хариу хүргүүлэх тухай

Хөдөлгөөн заслын мэргэжлийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шинжээчдийн тайлантай танилцаж дараах саналыг хүргүүлж байна.

Шалгуур 1-1.1-1.2, шалгуур 2-2.2-2.3, шалгуур 3-3.1-3.4, 3.6, шалгуур 4, шаулгуур 5, шалгуур 6, шалгуур 7-7.1, 7.3, 7.4, санал нийлж байна.


Шалгуур 1.3, 2.1, 3.5, 7.2, 8.1 эдгээр шалгууруудад дараах тайлбарыг хүргүүлж байна.

**1.3. Хөтөлбөр төлөвлөлтийн баримт бичгүүд**


- Эмнэл зүйн гардан үйлдийн шалгалтын тохиолдлын сантай болох, шалгах хуудсыг боловсруулах

**Тайлбар:**


- Бид 2010 оноос хойш жил бүр эмнэл зүйн тохиолдлын номыг боловсруулан гаргадаг бөгөөд тохиолдлын тоо, төрлийг жил бүр баяжуулж байна.



АШУУИС | СУВИЛАХУЙН СУРГУУЛЬ  
**ТӨЛӨВЛӨГДСӨН ЗОРИЛГОТОЙ  
ГАРДАН ШАЛГАЛТ**  
Улаанбаатар  
2013 он



АНГААХУЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ  
СУВИЛАХУЙН СУРГУУЛЬ  
СУРГАЛТЫН БОДЛОГО ХӨНӨРӨЛӨЛТӨЙН ГАЗАР  
**ТӨЛӨВЛӨГДСӨН ЗОРИЛГОТОЙ  
ГАРДАН ШАЛГАЛТ**  
Улаанбаатар  
2014 он



АНГААХУЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ  
СУВИЛАХУЙН СУРГУУЛЬ  
СУРГАЛТЫН БОДЛОГО ХӨНӨРӨЛӨЛТӨЙН ГАЗАР  
**ТӨЛӨВЛӨГДСӨН ЗОРИЛГОТОЙ ГАРДАН  
ШАЛГАЛТ**  
Улаанбаатар  
2014 он

D:/alban bicheg2018/A4

## 2.1 Сургалтын орчин

- Оюутнуудын цахим орчинд ажиллаж сурах орчны /ширээ, сандал/ хүртээмжийг сайжруулах

### Тайлбар:

- Цахим уншлагын танхимд 25 ширхэг компьютер, 25 ширхэг сандал, 25 ширхэг ширээ
- 208 тоот өрөөнд 30 ширхэг компьютер, 30 ширхэг сандал, 15 ширхэг ширээ /урт/
- 107 тоот өрөө /мэдээлэл технологи/ 40 ширхэг компьютер, 40 ширхэг сандал, 20 ширхэг ширээ /урт/ тус тус байгаа нь оюутнууд цахим орчинд хичээллэх, сурах орчин хангалттай гэж үзнэ.

## 3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

- Дотоод хамтын ажиллагаа Улаанбаатар хотоор хязгаарлагдаж байна.

### Тайлбар:

- Монголын бие бялдар хөдөлгөөн заслын холбоо, АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн Бие бялдар судлалын багш нар JICA олон улсын байгууллагатай хамтран сүүлийн 3 жил хөдөө орон нутгийн нэгдсэн эмнэлэгүүдэд сургалт явуулж байна. Жишээ нь: Архангай, Хөвсгөл, Дорноговь, Эрдэнэт, Дархан зэрэг хотуудад сургалт зохион байгуулж хамтран ажиллаж байна. Дэлгэрэнгүй тайланг 7-р бүлгээс харна уу.

## 7.2. Хөтөлбөрийн үр нөлөө:

- Мэргэжлийн танилцуулгыг олон нийтэд сурталчлан таниулах, зах зээлийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх, мэргэжлийн үнэлэмжийг сайжруулах.

### Тайлбар:

- Мэргэжил сурталчлах, олон нийтэд таниулах ажлыг бид хангалттай хийдэг гэж үзэж байна. Үүний нотолгоо нь 2013 оноос эхлэн жил бүрийн 09 дүгээр сарын 08-нд “Дэлхийн хөдөлгөөн засал”-ын өдрийг тэмдэглэн, олон нийтийг хамарсан сургалт, тусламж үйлчилгээ, сурталчилгааны ажлыг хийдэг тухай, 2011 оны 12 дугаар сараас эхлэн Монголын Бие Бялдар Хөдөлгөөн Заслын Холбооны эрдэм шинжилгээний олон улсын бага хурлыг жилд 1 удаа зохион байгуулдаг тухай, [www.facebook.com/mptamn](http://www.facebook.com/mptamn) хуудсыг тогтмол ажиллуулж ард түмэнд зөвлөгөө өгөн сурталчилдаг тухай, МҮОНТв-ийн 120/80 нэвтрүүлэг, Монгол HD телевизийн өглөө хөтөлбөрт оролцож мэргэжлээ сурталчилдаг тухай, хөдөө орон нутагт “Багш шавийн уулзалт” зохион байгуулж, сургалт явуулдаг тухай тайлангийн 7.4-р бүлэгт дэлгэрэнгүй тайлбар болон зурагтайгаар оруулсан. Мөн мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн анхны жилүүдэд 12-16 оюутан төгсөж байсан бөгөөд 2015 оноос эхлэн

төгсөгчдийн тоо 2 дахин ихэссэн нь хөдөлгөөн засалч мэргэжилтний зах зээлийн эрэлт хэрэгцээ, болон нийгэмд эзлэх байр суурь өсөж байгааг харуулж буй стратегийн бодит тоон үзүүлэлт юм (Хүснэгт 93).

**8.1. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.**

- Чанарын удирдлагын хорооноос хийсэн судалгаа, шинжилгээ, дүнгийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн ажлын биелэлтийг үнэлэх, дүгнэх

**Тайлбар:**

Чанарын удирдлагын хороо нь жил бүрийн 12 дугаар сард удирдлагын шинжилгээний журмын дагуу жил бүрийн 12 дугаар сард хуралдан судалгаа шинжилгээний үр дүн, дотоод аудитын хөтөлбөр, биелэлтийг үнэлэн дүгнэж дараа жилийн төлөвлөгөөнд тусгадаг.

СУВИЛАХУЙН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ



Н.НАРАНБААТАР

## ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан(огноо) ..... [Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж/Recommendations/**

## ҮІІ. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан(огноо) ..... [Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж/Recommendations/**